

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2021 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН БАЙНГЫН
ХОРООНЫ 6 ДУГААР САРЫН 29-НИЙ ӨДӨР /МЯГМАР
ГАРАГ/-ИЙН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
ТОВЬЁГ**

№	Хэлэлцсэн асуудал	Хуудасны дугаар
1.	<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	1-7
2.	<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	8-68
	1. Кино урлагийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2019.04.16-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг /	8-24
	2. Боловсролын ерөнхий хууль /Засгийн газар 2021.06.24-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх /	24-68

ТОВЧ ТЭМДЭГЛЭЛ

Хоёр.Боловсролын ерөнхий хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Засгийн газар 2021.06.24-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Боловсрол, шинжлэх ухааны дэд сайд Г.Ганбаяр, Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Батбаатар, мөн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ж.Ганбаатар, мөн газрын шинжээч Ж.Нарантуяа, Сургуулийн өмнөх боловсролын газрын дарга Ж.Мягмар, Бага, дунд боловсролын газрын дарга Т.Ням-Очир, мөн газрын Бага, дунд боловсролын бодлогын хэрэгжилт, зохицуулалт хариуцсан ахлах шинжээч А.Цолмон, Шинжлэх ухааны газрын дарга С.Мөнхбат, Дээд боловсролын газрын дарга С.Должин, Хуулийн хэлтсийн дарга Б.Мөнгөнбагана, мөн хэлтсийн ахлах мэргэжилтэн Ч.Баярмаа, Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн дэд захирал Т.Намнан, Боловсролын хүрээлэнгийн секторын эрхлэгч У.Туяа, Монголын Боловсрол, шинжлэх ухааны үйлдвэрчний эвлэлийн холбооны дарга З.Цогтгэрэл, Бүх нийтийн боловсролын төлөө иргэний нийгмийн үндэсний эвслийн зохицуулагч Д.Тунгалаг, Боловсрол судлаач П.Оюунаа, Монголын хувийн хэвшлийн бага, дунд сургуулиудын холбооны тэргүүн Н.Номин, Монголын хувийн хэвшлийн цэцэрлэгүүдийн үүсгэн байгуулагчдын холбооны тэргүүн А.Цэнгэл, Хувийн их дээд сургуулиудын төлөөлөл, Академич С.Нямзагд, Монголын багш нарын үйлдвэрчний эвлэлийн холбооны дарга Д.Мөнхбаатар нар “Үндсэн хууль” танхимаас оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Бад.Баярмаа, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, референт Н.Монголмаа нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаар илтгэлийг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрам, Ё.Баатарбилэг, Г.Мөнхцэцэг, Б.Баярсайхан, Ж.Мөнхбат, Н.Учрал, Т.Аубакир, Ц.Мөнхцэцэг, Х.Ганхуяг нарын тавьсан асуултад Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Батбаатар, Бага, дунд боловсролын газрын дарга Т.Ням-Очир, Дээд боловсролын газрын дарга С.Должин нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ё.Баатарбилэг, Ж.Мөнхбат, Ц.Мөнх-Оргил, Ч.Ундрал, Н.Учрал, Б.Баярсайхан, Ц.Мөнхцэцэг, Л.Энх-Амгалан, Г.Дамдинням нар үг хэлэв.

Г.Дамдинням: Боловсролын ерөнхий хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	15
Татгалзсан:	2
Бүгд:	17

88.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Хуралдаан 3 цаг 13 минут үргэлжилж, 18 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 94.4 хувийн ирцтэйгээр 13 цаг 18 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
БОЛОВСРОЛ, СОЁЛ,
ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА

Г.ДАМДИННЯМ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Боловсролын ерөнхий хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн төслүүдийн үзэл баримтлалыг Улсын Их Хурлын гишүүн, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан танилцуулна. Байнгын хорооны хуралдаанд ирсэн ажлын хэсгийг танилцуулъя. Лувсанцэрэнгийн Энх-Амгалан Боловсрол, шинжлэх ухааны сайд, Ганболдын Ганбаяр дэд сайд. Батбаатар Төрийн нарийн бичгийн дарга, Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ганбаатар, Мягмар Сургуулийн өмнөх боловсролын газрын дарга, Ням-Очир Бага, дунд боловсролын газрын дарга, Мөнхбат Шинжлэх ухааны газрын дарга, Должин Дээд боловсролын газрын дарга, Мөнгөнбагана Хуулийн хэлтсийн дарга, Цолмон Бага, дунд боловсролын газрын ахлах шинжээч, Нарантуяа Бодлого, төлөвлөлтийн газрын шинжээч. Баярмаа Хуулийн хэлтсийн ахлах мэргэжилтэн. Намнан Шинжлэх ухаан технологийн их сургуулийн дэд захирал Туяа, Боловсролын хүрээлэнгийн секторын эрхлэгч, Цогтгэрэл Монголын боловсрол, шинжлэх ухааны үйлдвэрчний эвлэлийн холбооны дарга, Тунгалаг Бүх

нийтийн боловсролын төлөө иргэний нийгмийн үндэсний эвслийн зохицуулагч, Оюунаа Боловсрол судлаач, Номин Монголын хувийн хэвшлийн бага, дунд сургуулиудын холбооны тэргүүн, Цэнгэл Монголын хувийн хэвшлийн цэцэрлэгүүдийн үүсгэн байгуулагчдын холбооны тэргүүн, Нямзагд Хувийн их, дээд сургуулийн төвүүдийн төлөөлөл, академич Мөнхбаатар Монголын багш нарын үйлдвэрчний эвлэлийн холбооны дарга.

Энх-Амгалан сайд танилцуулгаа хийе. Энх-Амгалан сайдад микрофон өгөөрэй.

Л.Энх-Амгалан: Байнгын хорооныхоо гишүүдийн энэ өглөөний амгаланг айлтгая. За ингээд Боловсролын тухай хуулийн шинэчилсэн найруулгынхаа үзэл баримтлалын талаар бас мэдээлэл хийе гэж бодож байна.

Өнөөдөр Монгол Улс оюуны чадавхаараа дэлхийд эхний 12 орны тоонд орж байгаа хэдий ч Хүний хөгжлийн индексээрээ 189 орноос 92-т, Боловсролын индексээр 189 орноос 103-т, Өрсөлдөх чадварын индексээрээ 64 орноос 60-д, Оюуны чадавхаа хэрэглэх ур чадвараар 49-д, Мэдлэг чадвараа хөгжүүлэх үзүүлэлт дээр 59-д орж байна.

2018 онд хийгдсэн нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгааны үр дүнгээс харахад 7-14 насны хүүхдийн сурч чадах үндсэн суурь чадвар болсон, унших чадвар 61.5 хувь, энгийн аргын тоо бодох чадвар 51.5 хувь байгаа зэрэг нь боловсролын чанар, үр дүнд чиглэсэн эрх зүйн шинэчлэл хийх практик хэрэгцээг илтгэж байна.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор алсын хараа 2050, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлагдаж, хүний хөгжил төвтэй хөгжлийн бодлого хэрэгжиж эхэлсэн. Уг бодлогыг үргэлжлэл болох Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл болон 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт “Хүн бүрд чанартай боловсрол эзэмших, тэгш боломжийг бүрдүүлж, боловсролыг хувь хүний хөгжил, гэр бүлийн амьдралын баталгаа, улс орны хөгжлийн суурь болгон насан туршийн суралцахуйн тогтолцоог бэхжүүлэх” зорилтыг тус тус дэвшүүлсэн.

Улс орны хөгжил дэвшлийн урт хугацааны эдгээр зорилтыг хангахад тулгуур болох боловсролын салбарын эрх зүйн зохицуулалт, түүнийг хэрэгжүүлж буй хууль тогтоомж хангалтгүй байгаа тул энэхүү шинэчилсэн найруулгыг боловсруулах эрх зүйн үндсийг бүрдүүлсэн болно оо. Түүнчлэн боловсролын хөгжлийн олон улсын чиг хандлага, өөрийн улсын хөгжлийн бодлого, төлөвлөлттэй уялдуулан боловсролын зорилгыг шинэчлэх, хувьсан өөрчлөгдөж байгаа дэлхий ертөнцөд шинээр бий болж буй өргөн боломж, түүний дотор технологийн дэвшлийг ашиглан боловсрол эзэмших арга, хэлбэрийг уян хатан, эрчимтэй болгохын хамт сургалтын хөтөлбөрийг залгамж холбоотой, тогтвортой байх нөхцөлийг хангах, үнэлгээний тогтолцоог сайжруулах, багш бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх сургалтыг чанаржуулах, сургуулийн хэв шинж, бүтэц, байршлыг оновчтой болгох эрх зүйн орчныг сайжруулах шаардлага байна.

Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдын сурлагын ахиц, амжилтын талаарх өөрийн болон хөндлөнгийн үнэлгээний дүн өөр хоорондоо зөрүүтэй, хот хөдөөгийн сургалтын чанар харилцан адилгүй байгаа нь сурлагын ахиц, амжилтыг тодорхой давтамжтайгаар, хөндлөнгөөс үнэлэх үнэлгээний тогтолцоог бүх шатны сургуульд нэвтрүүлэх шаардлагыг харуулж байна. Багшийн мэргэжил ажиллах нөхцөлд хөдөлмөрийн үнэлэмжийг эрс сайжруулах цогц механизм бүрдүүлэх замаар мэргэжлийн нэр хүнд, нийгмийн үнэлгээг дээшлүүлж, цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багшийн ажлын үнэлгээ, цалин хөлсийг хөдөлмөрийн бүтээмж, ажлын гүйцэтгэл, үр дүнтэй уялдуулснаар нийгэм дэх нэр хүнд, үнэлэмжийг нэмэгдүүлэх, багш бэлдэх үндэсний тогтолцоо бий болгох, чадваржуулах, сургалтын чанар, үнэлгээ, үр дүнг сайжруулах, чанартай багш бэлтгэх хэрэгцээ шаардлага байна. Боловсролын санхүүжилтийн өнөөгийн тогтолцоо нь хүртээмжийг нэмэгдүүлэхэд анхаарсан, боловсролын чанар гүйцэтгэхэд үр дүнтэй, уялдаа холбоогүй, нэг хүүхдийг сургаж буй бодит өртөг, зардал, ялгаа ихтэй, сургалтын хөтөлбөр болон боловсролын стандартыг хангах, сургалтын байгууллага төсөв санхүүжилтээ үр ашигтай захиран зарцуулах идэвх санаачилгыг урамшуулдаггүй зэрэг суртал сул талтай байна.

Боловсролын санхүүжилт нь боловсролын зорилго, стандартын хэрэгжилтийг хангах суурь нөхцөлийг бүрдүүлж, боловсролын үйлчилгээний гүйцэтгэл, чанар, үр дүнд чиглэсэн байх бөгөөд хүн бүрд тэгш боломж бүрд бүрдүүлэх, насан туршийн суралцахуйг дэмжих, сургалтын байгууллага нь төсөв санхүүгийн хувьд бие даан шийдвэр гаргах эрх мэдлийг зохистой түвшинд бий болгох, үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэх зорилтыг хангадаг эрх зүйн зохицуулалтыг бий болгох шаардлагатай байна. Ерөнхий боловсролын сургуулийг хагас бие даасан тогтолцоонд шилжүүлэх, нэг хүүхдэд ногдох хувьсах зардлын санхүүжилтийн аргачлалыг шинэчлэх, сургуулийн бүтэц, байршил, хэв шинжийг оновчтой үйлдвэрийг тогтоох, сургалтын чанарт суурилсан багшийн цалин, урамшууллыг олгох нөхцөлтэйгөөр жил бүр төсөв, санхүүгийн зохистой дэмжлэг үзүүлж болох эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлнэ.

Боловсролын зээлийн санг Засгийн газрын тогтоосон тэргүүлэх чиглэлийн мэргэжлийн хөтөлбөрт элсэгчид их, дээд сургууль, коллежийн тэргүүлэх мэргэжлийн чиглэлээр ахисан шатны суралцагчдын сурлагын амжилт, судалгааны ажлын чанартай уялдуулан шаардлага хангасан тохиолдолд сургалтын тэтгэлэг, тусламж, зээл олгох төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, оюутны болон багшийн хөгжлийг дэмжих хэлбэрээр өөрчлөн зохион байгуулна.

Дээд боловсролын сургалтын байгууллагын статус, хэв шинж, бүтэц, засаглалын тогтолцоо, хөтөлбөрт тавигдах шаардлага, санхүүжилтийн хэлбэрийг үр ашигтай, оновчтой болгох хэрэгцээ байна.

Шинжлэх ухаан, дээд боловсролын уялдааг өргөжүүлэх судалгаа, их сургуулийн шинжлэх ухааныг бэхжүүлэн хөгжүүлэх эрх зүйн орчныг бий болгох шаардлага үүсэж байна. Дээд боловсролын сургалтын байгууллагын статус, хэв шинж бүтэц сайжирч, удирдах зөвлөлд ажил олгогч, мэргэжлийн холбоод, олон нийтийн байгууллагын

төлөөлөл, бизнес, хөрөнгө оруулагчдын төлөөллийг оруулснаар сургалт, судалгаа, үйлдвэрлэл, академик эрх, чөлөө, боловсролын чанарын баталгааны тогтолцоо сайжрах болно. Их дээд сургуулиудын засаглал, удирдлагын хараат бус, бие даасан байдлаар хангагдаж, ахисан шатны сургалт, судалгаа, олон улсын жишигт хүрэх нөхцөл бүрдэнэ.

Бүх шатны боловсролын чанарын баталгаажуулалт нь байгууллагын сургалт, судалгааны үйл ажиллагааны гүйцэтгэлийн болон чанарын удирдлагыг сайжруулахад чиглэж, нээлттэй, бүх талын оролцоог хангасан тасралтгүй үйл ажиллагаа бүхий тогтолцоо бүрдэнэ ээ. Боловсролын магадлан итгэмжлэх үйл ажиллагааг олон улсын жишигт нийцүүлж, төрөөс хараат бус, мэргэжлийн олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөхүйц болох зорилт, зорилтыг орууллаа.

Боловсролын сургалтын байгууллагын засаглалыг бие даалгах, удирдах албан тушаалд томилогдох шалгуурт мэргэшсэн чадавхын зарчмыг баримтлан эрх, үүргийг нарийвчлан тусгалаа. Боловсролын салбарын удирдах ажилтны томилгоо нь шатлан дэвшсэн мерит, мэргэшсэн тогтолцоотой болсон байна.

Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын харьяа байгууллага болон аймаг, нийслэл, дүүргийн боловсролын газар, хэлтсийн ажлын чиг үүрэг, зохион байгуулалтын хэлбэрийг оновчтой болгож, өөрчилнө.

Монгол Улсын урт хугацааны бодлогын бичиг баримт болсон и-монгол засаглал, цахим засаглал, үндэсний хөтөлбөрийн хүрээнд мэдээлэл, харилцаа холбооны технологийг ашиглах алсын харааг тодорхойлж, боловсролын салбарын бодлого, үндэсний мэдээлэл, харилцаа холбооны технологийн бодлогын зохицуулалттай нийцүүлэх шаардлагатай байна.

Боловсролын цахим мэдээллийн нэгдсэн сан төрийн болон иргэдийн мэдээллийн аюулгүй байдлын эрх зүйн орчнуудыг тусгалаа. Тэгш боломжтой. Насан туршдаа тасралтгүй суралцахуйн хүрээнд сургалтад харилцаа холбоо, мэдээллийн технологи, үр дүнтэй ашиглах арга зүйд суралцах, цахим сургалт, контент бүтээх, сургалтын нээлттэй нөөц материал болон бусад платформыг ашиглах орчин, суралцахуйн удирдлагын системийг бий болгох орчныг бүрдүүлнэ.

Боловсрол эзэмших танхимын болон танхимын бус хосолсон сургалтыг үнэлэх, дүйцүүлэх баталгаажуулах асуудлыг тусгасан болно. Насан туршийн суралцахуйн эрх зүйн үндэс орчныг бүрдүүлж, салбар дундын мэргэжлийн үндэсний шаталсан бүтцийг боловсролын түвшин бүрд хэрэглэж хүлээн зөвшөөрөх, баталгаажуулах үйл ажиллагаа хэрэгжих нөхцөл бүрдэнэ. Боловсролын салбар эрх зүйн шинэчлэл хийгдсэнээр, ядуурлын бүх төрлийг эцэс болгох, орлогын тэгш, богц байдлыг багасгах, нийт хүн амын 80 хувь нь дундаж болон чинээлэг давхаргын ангилалд багтах, суурь болон мэргэжлийн боловсролд хамрагдалтын түвшин 100 хувьд хүргэж, насан туршийн суралцахуйн тогтолцоог шинэчлэх, хүний хөгжлийн үзүүлэлтээр улс орнуудын жагсаалтад эхний 70 орны 1 болох хөгжлийн бодлогоо бүх түвшинд хэрэгжүүлэх

чадвартай, авлигаас ангид, иргэдийн оролцоог хангасан, мэргэшсэн тогтвортой засаглал төлөвших үндсийг бүрдүүлэх суурь бий болно.

Хүний хөгжлийн үндсэн хэмжүүр нь улс орны болон хувь хүний хөгжилд байх гол зарчмыг үндэс болгон хуулийн төслийг боловсруулсан ба иргэн бүр эрүүл байж, боловсрол эзэмшиж, амьжиргаандаа хүрэлцэхүйц, орлоготой боломжийг бүрдүүлж, ядуурал, ажилгүйдлийг бууруулж, дундаж орлоготой өрхийн тоог нэмэгдүүлж, хүн амын амьжиргааны түвшинг дээшлүүлэх, мэдлэгт суурилсан нийгэм, ур чадвартай, зөв хандлагатай Монгол хүнийг төлөвшүүлэх зорилгод хүрнэ.

Боловсролын тухай хуулийн шинэчилсэн найруулгын үзэл баримтлалыг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлж, дэмжиж өгөхийг хүсье.

Г.Дамдинням: Энх-Амгалан сайдад баярлалаа. За гишүүдийн нэр авахаас өмнө Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 10-д заасны дагуу хэлэлцэх эсэх дээр цахим дэгээр явж байхад асуулт 2 минут, шаардлагатай бол нэмэлт 1 минутыг гишүүний саналаар, мөн араас нь бас санал 3 минут хүртэл байгаа гэдгийг сануулъя.

Хуулийн төсөл санаачлагчийн илтгэлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү. За цахимаар гишүүд байна уу? За Мөнхцэцэг гишүүн кноп дарчих. Мөнхцэцэг гишүүнээр тасалъя. Цахимаар учрал гишүүн, өөр байгаа юу? Ундрaм гишүүн асуулт асууя. Микрофон өгөөрэй.

Ч.Ундрaм: За маш олон жил хэлэлцсэний үндсэн дээр Боловсролын багц хуулийн шинэчилсэн найруулга орж ирж байгаад маш их баяртай байна. Тэгээд ер нь бол боловсролын байгууллагад олон улсын жишигт нийцэх үндэсний хөтөлбөр тогтвортой хэрэгжинэ гэж ингэж ойлгож байгаа.

За асуулт. Нэгдүгээрт.Боловсролын тухай хуулийн төслийн 43.1.3-т “Боловсролын байгууллагын үйл ажиллагааны гүйцэтгэл, чанар, үнэлгээний үр дүнд үндэслэн олгох нэмэлт урамшууллыг цэцэрлэг, сургуульд өгөхөөр” тусгасан байгаа нь маш зөв. Үр дүн, гүйцэтгэлд шууд суурилсан урамшуулал болж энэ хүмүүсийн орлого нэмэгдэнэ гэж ойлгож байгаа. Гэхдээ энэ нь хэрэгжихдээ хэрвээ шударга бус, ил тод биш, хэн нэгэн этгээд, байгууллагын үзэмжид суурилаад явах юм бол энэ нь эргээд сөрөг үр дагавар болно. Тэгэхээр энийг яг жинхэнээсээ шударгаар үр дүн, гүйцэтгэл шууд хамаарахаар тийм байдлаар хэрхэн хэрэгжүүлэх вэ гэдэг асуулт байна.

Хоёрдугаарт.Хувийн сургуулиуд хувьсах зардал өгөх үү? Мөн татвар энэ хүмүүсээс авах юм уу? Хувийн сургуулиуд маань ашгийн төлөө байгууллага байх юм уу? Олон улсын нийтлэг жишгээ дагаад ашгийн бус байгууллага гэж явах юм уу? асуулт байна.

Гуравдугаарт.Их, дээд сургуулиудын хувьд их дээд сургуулиуд өөрсдөө статус нь төрийн өмчит үйлдвэрийн газар гэдэг статустай байдаг. Багш нар нь төрийн албан

хаагч, гэхдээ төрийн үйлчилгээний албан хаагчид байдаг. Заримдаа яг төрийн албан хаагчдынхаа тэр категорид багтаад явдаг, заримдаа шаардлагагүй үед тэнд нь багтдаггүй. Тэрнээс болоод төрийн албан хаагчийн авдаг урамшууллыг ерөөсөө авч чаддаггүй. Тэгэхээр энийг нэг талд нь гаргаж цэгцлэх үү гэдэг асуудал байна. За дээрээс нь одоо ба боловсролыг тэгш.../минут дуусав/

Г.Дамдинням: Ундрaм гишүүнд нэг минут.

Ч.Ундрaм: Боловсролыг тэгш хүртээмжтэй байлгахын тулд үндэсний цөөнхийн асуудал байна. Нэгдүгээрт. Баян-Өлгий аймагт байгаа казахууд, тэр дундаа Баян-Өлгий аймгийн Цэнгэл суманд байгаа цөөнх доторх цөөнх гээд тува үндэстэн байна. Энэ хүүхдүүдтэй холбоотой ямар бодлого явж байгаа вэ? Дээрээс ажилчин, залуучуудын сургууль гээд би маш олон удаа ярьж байгаа. Энэ сургуулийн асуудал хэрхэн тусч байгаа вэ? За мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлаар асуумаар байна. Тэгээд Дээд боловсролын тухай хуульд заавал коллеж, дээд сургууль, их сургууль гээд дээд сургууль гээд хаана ч байхгүй энэ заалт яагаад орж ирж байгаа юм бэ гэдэг дээр бас их гайхаж байна. Энийг хэлж өгөөч. Ер нь бол их сургуулийн үнэлэмжийг дээшлүүлж байгаа нь бол маш зөв. Бид нар яг энэ олон улсын түвшинд олон улсын топ сургуулиудын эгнээнд очих их сургуулиудыг төрүүлэхэд энэ бол маш том.../минут дуусав/

Г.Дамдинням: Ундрaм гишүүн 6 бараг 7 асуулт асуучихлаа. Энх-Амгалан сайд ариулах уу?

Л.Энх-Амгалан: Ундрaм асуултад хариулъя. Үр дүнд суурилсан санхүүжилт гэж энэ багшийн ажлын үр дүн, тухайн хариуцсан сурагчийнх нь сурлага, амжилтын ахицтай уялдуулж үр дүнд суурилсан санхүүжилт гэдэг шинэ санхүүжилтийн эх үүсвэр энэ хуулиар тийм эрх зүйн орчин бий болж байгаа юм. Одоо боловсролын салбарт бол ерөөсөө суурь санхүүжилт, хувьсах зардлын санхүүжилт гэж 2 санхүүжилтийн эх үүсвэр байгаа. Тэгэхээр үндсэндээ бол өнөөдрийн энэ байгаа санхүүжилтийн тогтолцоо бол дандаа байгууллага санхүүжүүлдэг. Сургууль, цэцэрлэгийг, байгууллагыг санхүүжүүлдэг нь санхүүжилтийн тогтолцоо юм байна лээ. Суурь санхүүжилтийнх нь зардал нь ч адилхан, зардал ч адилхан нөгөө хувьсах зардалд орж байгаа тэр зардлууд нь ч гэсэн ерөөсөө яг тэр нөгөө багшийн хөгжлийг дэмжсэн, эс үгүй бол хүүхдийн сурлагын амжилтыг дэмжсэн, хүүхдийн сурах орчныг сайжруулах ийм хувьсах зардлууд ерөөсөө байдаггүй юм байна.

Тийм учраас одоогийн мөрдөгдөж байгаа бид нар хувьсах зардлынхаа тэр 10 зардлуудаа жаахан өөрчилж, яг үр дүнд чиглэсэн ийм санхүүжилтийнх нь хэлбэр лүү оруулъя гэдэг ийм зарчим яг энэ хууль дээрээ тусгасан. Дахиад энэ дээрээ нэмэх нь үр дүнд суурилсан санхүүжилт гэдэг 3 дахь санхүүжилтийн эх үүсвэрийг бид нар оруулж ирж байгаа юм. Тийм учраас энэ санхүүжилтүүдийг бий болсноороо өнөөдөр байгаа манай багш нарын цалин, хөдөлмөрийн хөлс, хөдөлмөрийн үнэлэмжийн асуудлууд бол

нэлээн шинэ түвшинд очно. Ерөнхийдөө бол шинэ төгсөж байгаа багш болбол анхны цалин нь бол 750 мянган төгрөгөөс эхэлж байгаа юм байна лээ. 750 мянган төгрөг.

За бид нар энийг ер нь цаашдаа хамгийн багадаа шинээр ажилд орж байгаа багшийн цалинг 1 сая төгрөгөөс эхлүүлээд, тэрнээсээ дээшлүүлээд багшийнх нь нөгөө авч байгаа зэрэглэл, заах арга, тэргүүлэх, зөвлөх багшийн ангиллууд. За нэмж байгаа, манай салбарт байгаа багш нарын цалин дээр нэмэгддэг баахан нэмэгдлүүд байна. Энэ нэмэгдлүүдийг бид нар жаахан цэгцэлье.../минут дуусав/

Г.Дамдинням: Энх-Амгалан сайдад минут нэмж өгөөрэй. Хариултыг нь гүйцээгээд өгчих.

Л.Энх-Амгалан: Энэ нэмэгдлүүдийг жаахан цэгцэлье. Тэгээд үр дүнгийн нэмэгдэл гэдэг нь бол угаасаа цалингийн нэмэгдэл гээд манай багш нар нийтдээ ойлгомжтой байсан юм байна лээ. Тийм учраас тэр үр дүнгийн нэмэгдлийг нь үндсэн цалингийнх нь нэг хэсэг болоод цаашдаа бид нар энэ чадварлаг багш гэдэг хөтөлбөрөө хэрэгжүүлж ур чадварын нэмэгдэл гэдэг бол жинхэнэ чадварлаг багш нартаа, тэр үндсэн цалин дээр нь нэмэх ийм цалингийн урамшууллын шинэ тогтолцоо бас бий болгож байгаа гэдгийг бас танд хэлье гэж бодож байна.

Хоёрдугаарт нь их, дээд сургуулиудын статусын асуудал байгаа юм. Энэ үнэхээр их ойлгомжгүй асуудлууд байсан. Өнөөдөр Монгол улсад 88 их, дээд сургууль байгаагаас 37 их сургууль, 48 дээд сургууль, 3 коллежтой. Эндээс нийтийн өмчийн 20 их сургууль, дээд сургууль байгаа. Эд нарын зарим нь төрийн өмчийн, төсвийн, улсын өмчит компанийн статустай, зарим нь төрийн бус байгууллагын статустай гээд статус нь маш тодорхой байхгүй байгаа учраас бид нар ер нь цаашдаа ер нь ашгийн төлөө байгаа хувийн их, дээд сургуулиудыг бид нар тэр компанийн хуулиараа яв л гэж байгаа юм.

Ер нь цаашдаа их, дээд сургуулиудын засаглал бол энэ корпорацийн засаглалууд. Тэр нь төрийн өмчтэй байна уу, хувийн өмчтэй байна уу ер нь цаашдаа болбол тэгээд корпорацийн засаглал руу шилжих зайлшгүй шаардлага өнөөдөр үүсэж байна гэж харж байгаа. Ашгийн төлөө бус байх юм бол тэр нь нөгөө нийтийн эрх зүйн хуулиараа зохицуулагдаад явдаг ийм зохицуулалтуудыг бид нар их ойлгомжтой болгож өгье гэж байгаа.

Ер нь хувийн дунд сургуулиуд, өндөр төлбөртэй дунд сургуулиуд, хувийн их, дээд сургуулиуд зайлшгүй татвар төлөх л ёстой байхгүй юу. Түүнээс биш төрийн бус байгууллагаараа бүртгүүлчхээд ингээд иймэрхүү татвараас зайлсхийсэн, за ингээд өөрсдийнхөө девидентийг өөр хэлбэрээр авдаг ийм маягаар ер нь байж болохгүй юм байна. Тийм учраас ашгийн бол компанийнхаа хуулиараа, ашгийн бус байх юм бол боловсролын байгууллага гэдгээрээ бүртгэгдээд тэр сургалтынхаа үйл ажиллагааг явах энэ эрх зүйн орчнуудыг л ойлгомжтой бол болгоё л гэсэн ийм зохицуулалтууд байгаа.

За тэр нөгөө ажилтан, залуучуудын сургуультай холбоотой асуудал дээр Ням-Очир дарга энэ дээр тодорхой хариулт хэлчхээрэй. Ундрaм гишүүн их олон удаа асуугаад байгаа. Та 2 бас очиж ажилласан гэж ойлгож байгаа шүү дээ? Ажилласан байх аа. Манайх нэг тодорхой шийдэл гаргачихсан юм байна лээ. Тэр их зовлонтой сургууль. Тэрийг Ням-Очир дарга нэмээд хариулт өгчих.

Г.Дамдинням: Энх-Амгалан сайд болчихсон уу. За Энх-Амгалан сайдад микрофон дахиад өгөөрэй.

Л.Энх-Амгалан: Их, дээд сургуулиудын багш нарын цалингийн асуудал бол цалин, цолны нэмэгдэл, эрдмийн зэрэглэл гээд энэ дээрээсээ нэмэгдээд үндсэндээ бол хамгийн бага цалинтай хүн нь 1.5 сая, хамгийн их нь 2.5 сая төгрөг гэж болсон юм байна лээ шүү дээ. Манай их, дээд сургуулиудынх. Хэрэв эд нар маань их, дээд сургуулиудын багш нар яг төрийн албан хаагчдын цалингийн зэрэглэлээр явах юм бол ийм цалин авч чадахгүй. Тийм учраас нөгөө 2018 онд төсвөөс санхүүжилт олгохоо больсон учраас их, дээд сургуулиудын багш нар бол өөрсдөө төрийн албан хаагчдынхаа цалингийн ангиллаас гарчихсан юм байна лээ. Тэгэхээр нэгэнт гарчихсан учраас бол юу гэдэг юм. Төрийн болон их, дээд сургуулиудын багш нарын цалин урамшуулал, нийгмийн хамгааллын асуудлуудыг энэ хууль дээрээ жаахан ойлгомжтой болгож зохицуулж өгч байгаа. Тэгэхгүй бол бид нар зөвхөн төрийн албаны тухай хууль, төрийн албаныхаа ажилчдын цалингийн ангилал, шатлалаар явах юм бол одоогийнхоосоо дордож байгаа байхгүй юу. Тийм учраас 2 л зүйл үүсчхээд байгаа юм байна л даа Ундрaм гишүүн ээ. Багш нар маань нэг болохоор өндөр цалингаа авч байгаа учраас төрийн албан хаагчдынхаа цалингийн ангиллаас гаръя гэчихдэг. Гарчихаар нөгөө тэтгэвэрт гарахдаа авдаг нийгмийн баталгаа, ажилласан жилийн нэмэгдлүүд гээд багш нарын авдаг боловсролын салбарт байдаг нийгмийн баталгааны асуудлуудад хамрагдаж чадахгүй нэг ийм л зүйл үүсчхээд байгаа байхгүй юу. Тэгэхээр энийгээ л бид нар энэ өргөн барьж байгаа хуулиар бол жаахан цэгцэлье л гэсэн ийм эрх зүйн зохицуулалтуудыг хийсэн.

За хоёрдугаар асуудал бол ер нь цаашдаа бид нар энэ хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асуудлуудыг, хөгжлийн бэрхшээлтэй гэж ер нь ярихаа больё. Тусгай хэрэгцээтэй хүүхдүүд, тусгай хэрэгцээтэй иргэн гэж ер нь явах ёстой юм байна гэдэг зохицуулалт. Ер нь цаашдаа тусгай хэрэгцээтэй хүүхдүүдийг тусгайлж, нийгмээс тусгайлж тусад нь сургууль, цэцэрлэг барьдаг биш хэрэгцээнийх нь онцлогт тохирсон сургалтын ямар хэлбэрүүдийг бид нар ямар аргаар өгөх ёстой юм бэ гэдэг энэ зүйлүүдийг бид нар энэ хууль дээрээ нэлээн тодорхой болгож байгаа. Үнэхээр сургууль, цэцэрлэгт хамрагдаж чадахгүй байгаа хүүхдүүд дээр магадгүй гэрээр нь багш нар очих эс үгүй бол мэдээлэл технологи дээр суурилсан алсын сайн сургалтууд өгөх, цаашдаа бол бид нар тусгай сургууль, тусгай цэцэрлэг гэж ер нь барих шаардлагагүй юм байна лээ.

Ер нь одоогийн байгаа ердийн цэцэрлэг сургуулиуд дээрээ тусгай хэрэгцээтэй хүүхдүүдийг бүрэн тэгш хамруулах энэ зарчим л явах нь зүйтэй юм байна. Энэ тэгш

хамруулах зарчим бол зөвхөн тусгай хэрэгцээтэй хүүхдүүд ч биш, таны хөндөж байгаа нөгөө цөөнх, үндэсний цөөнх болсон Тува хүүхдүүдийн цэцэрлэгийн хамрагдалт сургуулийн хамрагдалтад энэ зүйлүүдийг тэгш хамран сургах хамрагдалт гэдэг энэ зарчим бас багтаж орж байгаа юм гэдгийг бас танд хэлье. Залуучуудын юу билээ, ажилтан залуучууд энийг л энэ Учрал гишүүн ер нь гишүүн болсноос хойш л яриад байгаа юм даа. Энийг нэг тодорхой болоод хэлээдхээч асуудал нь яг юу байгаа билээ гэдгийг.

Г.Дамдинням: Боловсролын яамны газрын дарга Ням-Очир гүйцээж хариулна. Зүүн жигүүрийн урд микрофоныг өгөөрэй.

Т.Ням-Очир: Ундрам гишүүний асуултад хариулъя. Энэ ерөнхий боловсрол дээр оройн анги, эчнээ ангийн хөтөлбөр зохицуулалт байхгүй. Тэгээд ажилтан залуучуудын ээлжийн сургууль анх байгуулагдахдаа тухайн үедээ Чингэлтэй дүүргийн 5, Сүхбаатар дүүргийн ээлжийн сургууль гээд тухайн үеийн хуулийнхаа дагуу орой эчнээ хөдөлмөр хичээллэдэг ийм сургууль байсан юм. Тэгээд 2016 оны хуулиар энэ зохицуулалтууд байхгүй болоход ээлжийн сургуулийг тухайн орон нутгийн засаг захиргаа татан буулгах ёстой байсан. Буулгаагүй. Тэгээд 2018 онооноос хойш энийг хуульд нийцүүлээд, татан буулгах юм уу, өөр сургуультай нэгтгээд явуулъя гэдэг чиглэлийг яамнаас бол тухайн орон нутагт нь өгч байсан.

Тэгээд сая бид нар шийдлийг нь олохдоо бол ажилтан залуучуудын ээлжийн сургуулийн суралцагчдыг бол насан туршийн боловсролын төв рүү буюу боловсрол нөхөн эзэмшдэг энэ чиглэлээр нь насан туршийн боловсролын төв рүү суралцагчдыг нь шилжүүлээд сургуулийн багш, ажилчдыг бол шинээр баригдаж байгаа тухайн орон нутгийн сургуулиудтай нэгтгээд шийдье гэдэг шийдлийг гаргаад нийслэл дээр захирамж шийдэл нь яг бид нарын төлөвлөсний дагуу гарахаар явж байгаа гэсэн ийм мэдээллийг өгсөн. Өнгөрсөн 7 хоногт бид нар очиж ажиллахаар төлөвлөсөн боловч гишүүний ажил болоогүй учраас хойшилсон. Тэгээд дүүргийн боловсролын хэлтсийн дарга бид хоёр бас очиж захиралтай нь уулзаж тодорхой чиглэлүүдээ ярилцаад ер нь цаашдаа Сүхбаатар дүүрэг дээр шинээр баригдаж байгаа сургуульдаа нэгтгэе, үйл ажиллагаа, менежментийг нь тодорхой чиглэлээр удирдаад явъя гэдэг байдлаар ярилцсан байгаа.

Г.Дамдинням: Сая цахимаар нэрээ өгчихсөн байсан Ням-Осорын Учрал гишүүн, Цэрэнжамцын Мөнхцэцэг гишүүн, Гомпилдоогийн Мөнхцэцэг гишүүдийг нэрийг асуулт асуух гишүүдийн нэрд оруулаарай. Одоо Ёндонпэрэнлэйн Баатарбилэг гишүүн асуулт асууна.

Ё.Баатарбилэг: За минут богино учраас би хуулийн төслийг аваад сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын хуулийг нь л боловсролын ерөнхий хуулийг ерөнхийд нь жаахан гүйлгэж харж харлаа. Нэлээд олон зарчмын асуудлууд байна. Зүгээр товчхон товчхон хэдэн асуулт асууя. Минут богино байгаа учраас. Ерөнхий боловсрол гэж 12 жилийнхээ сургалтын агуулгын түвшинг ойлгоно гээд хуульчилчхаж

байгаа юм байна. Тэгэхээр бага боловсрол, суурь боловсрол гэж байхгүй болж байна гэж ойлгосон. Тэгэхээр энэ ерөнхий боловсролын сургуулийг шууд 12 жилээр эзэмшинэ гээд ерөнхий боловсролын хуульдаа заачхаж байгаа юм. Тэгээд сургуулийнхаа хэв шинж дээ бол ингээд байна л даа. Ерөнхий боловсролын сургуулийн бүтцийг 1-5 ангитай. Бага сургууль, цэцэрлэг, бага сургуулийн цогцолбор, 1-9 дунд сургууль, бүрэн дунд, ахлах гэж ойлгоно гээд баахан ангилчихсан. Тэгээд дунд, бүрэн дунд, ахлах сургууль төгсөгчид гэрчилгээ олгоно гэхихсэн. Тэгэхээр ерөнхий боловсрол эзэмшсэн гэрчилгээ гэж зөвхөн 12 төгссөн хүүхдэд л авна. Энэ сургуулийн хэв шинжээр бол тэд дүгээр сургууль төгссөн гэхээс биш боловсрол эзэмшсэн гэж авахгүй шүү дээ, нөхдөө. За концепцын нэг ийм юм байгаа.

Хоёрт сургуулийн хэв шинж дээр СӨБ-ыг яагаад оруулж байгаа юм. 1-5 дээр СӨБ давхар ороод ирж байна шүү дээ цэцэрлэг гэж. Ерөнхий боловсролын юун дээр сургуулийн хэв шинж дээр цэцэрлэгийг хамруулахгүй ээ, энийг яагаад хамруулж байгаа юм бэ гэдэг нэг ийм асуудал байгаа.

Гуравдугаарт аймаг, нийслэлийн Засаг даргын бүрэн эрх дээр болохоор иргэн суурь боловсрол эзэмшүүлэх асуудлыг хэрэгжүүлэх, төлөвлөгөө баталж хэрэгжүүлэх гэсэн юм явж байх. Энэ ямар учиртай юм. Дараагийнх нь энэ сум, тосгон, багийн ерөнхий сургуульд хүүхдийн тооноос хамаарч холимог бүлгээр хичээллэж болно гэж холимог бүлгээр.../минут дуусав/

Г.Дамдинням: Баатарбилэг гишүүн нэг минут.

Ё.Баатарбилэг: Холимог бүлгээр хичээллэнэ гэдгийг би ойлгохгүй байна л даа. За дараагийнх нь энэ хөдөлмөрийн зах зээлд 12 дугаар анги төгссөн хүүхдийг хөдөлмөрийн зах зээлд шилжихэд бэлдэнэ гэж байх юм. За энийгээ тайлбарлаад өгчхөөрэй гэж байгаа юм. За дараагийнх нь Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын тухай хуульд орон нутгийн чиг үүрэг, сургалтын байгууллагын барилга байгууламж, хөдлөх хөрөнгийн ашиглалт, засвар үйлчилгээ л гэж байгаа шүү дээ. Энэ хуульдаа захирагдаж бусад хуулиуд явна шүү дээ. Энд болохоор барилга, байгууламжаар хангах гээд ороод ирсэн байх. Аймаг, нийслэлийн Засаг даргын бүрэн эрхэд. Нөгөө нэгжийн хуулиасаа давсан том юу ороод ирсэн байна шүү дээ. Энийг юу гэж үзэж байгаа вэ? Энэ шууд зардал гэж юм ороод ирсэн байх юм. Сургалтын шууд зардал. Улсын төсвөөс санхүүжүүлэх хэсэг гээд. Тэгээд төрийн бус өмчийн хувийн сургууль, цэцэрлэгийн асуудлууд дээр энэ ямар учиртай юм ороод ирэв гээд. За энэ сургууль, цэцэрлэгүүд.../минут дуусав/

Г.Дамдинням: Хэн хариулах вэ? Энх-Амгалан сайд.

Л.Энх-Амгалан: Манай энэ Боловсролын хуулийн хамгийн том шинэчлэлийн концепцын шинж чанартай асуудал бол ер нь цөмөөрөө энэ 12 жилээр заавал боловсрол эзэмшдэг ийм тогтолцоо руу шилжье л гэж байгаа юм. Энэ яагаад ийм тогтолцоо руу шилжих шаардлага гарч байгаа юм бэ гэхээр бид нар их олон зүйлийг бодож тунгаамаар юм байна лээ. Бид нар чинь 9 дүгээр ангиасаа МСҮТ рүү

шилжүүлээд хэсэг хүүхэд. 8-10 мянган хүүхэд л юм байна л дээ. Жил бүхэн МСҮТ дээр 40 мянга орчим хүүхдүүд байгаад байгаа юм. Тэгээд МСҮТ-ээс 9 дүгээр ангиасаа МСҮТ рүү шилжсэн хүүхдүүд 2.5 жил МСҮТ-д сураад тэгээд буцаад гарч ирээд дахиад 18 нас хүрээгүй гээд 6 сар хүлээх болж байгаа байхгүй юу. Энэ нэгдүгээр үндэслэл.

Хоёрдугаар үндэслэл бол мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвөөр сурч сургуульд орсон хүүхдүүд нөгөө ерөнхий боловсролоо авах ёстой. Ерөнхий боловсролын гэрчилгээ авах ёстой. Гэтэл ерөнхий боловсролынхоо бүрэн дундынхаа үзэх ёстой хичээлийнхээ бараг 50 хувьд нь хүрэхгүй хичээлийг энүүгээр үзчихэж байгаа юм, дутуу үзэж байна гэсэн үг. За хоёрдугаарт нь үзэх ёстой мэргэжлийнхээ хичээлээ бас 100 хувь үзэж чаддаггүй. Тэр чадвараа, мэргэжлээ эзэмшиж чаддаггүй, дахиад 40-50 хувь эзэмшдэг нь судалгаагаар харагдаж байгаа юм. Тэгээд ерөнхий боловсролынхоо гэрчилгээг авах хэмжээнд бүрэн дунд боловсролоо ч эзэмшиж чадсан юм байхгүй, мэргэжлийн боловсролоо ч эзэмшиж чадсан юм байхгүй нэг ийм заримдаг хүүхдүүдтэй болчихоод байна. Тийм учраас бид нар ерөөсөө нийтээр нь 12 дугаар ангийг нь төгсгөөд, 12 дугаар анги төгссөн хүүхэд магадгүй 3 сар гэдэг юм уу 6 сар гэдэг юм уу ер нь МСҮТ-ийг 1 хүртэлх жилийн хугацаатай болгочихъё. Ингээд богино хугацаанд 18 нас хүрсэн хүүхэд бол мэргэжилтэй богино хугацаанд сурах, дадлагажих ийм боломжийг нь олгоё. Ер нь бид нар цаашдаа яг энэ нийтээр нь 12 жилийн боловсролтой болгож байгаа тогтолцоогоо дамжуулж ахлах ангийн төрөлжсөн сургуулиудыг бий болгоё. Ер нь 10, 11, 12 дугаар анги дээр нь мэргэжлийн өөрийнх нь сурах авьяас сонирхол, чадвар дээр нь үндэслэсэн төрөлжсөн сургуулиудыг МСҮТ дагасан.../минут дуусав/

Г.Дамдинням: Бусад асуултуудад нь хэн хариулах юм. За Энх-Амгалан сайд үргэлжлүүлье.

Л.Энх-Амгалан: Тийм учраас энэ төрөлжсөн ахлах сургуулиудыг бий болгоё гэдэг ийм бодлого, концепцууд орж ирж байгаа юм. Ер нь цаашдаа бид нар Улаанбаатар хот дээр хөдөөгийн сургуулиудын хамрагдалт, ачаалал хөдөөгийн сургууль, Улаанбаатар хотын сургуулийн өмнөх боловсрол дээр байгаа ачаалал өдөр, шөнө шиг ялгаатай байгаа учраас магадгүй бид нар нийслэлд томоохон барилга баригдаж байгаа энэ хорооллууд дээр, гэр хорооллын цэцэрлэг, бага сургуулийн ийм концепцоор барьж байж ер нь цаашдаа бүх сургуулийн өмнөх боловсролд хамрагдах хүүхдүүдийнхээ хамрагдалтыг нэмэх, бага сургуульд орох хүүхдүүдийнхээ хамрагдалтыг нэмэх ийм концепц юм байгаа юм. Энийг бүр Баатарбилэг сайд байхдаа л анх гаргасан концепц юм байгаа юм шүү дээ, Баатарбилиг сайд тийм ээ.Юу гэхээр Хүрээ сургууль, Хүрээ цэцэрлэг энэ их зөв концепц юм байна лээ. Тийм учраас бүгдэд нь энэ 12 жилийн сургууль барина гэдэг нэгдүгээрт маш их хөрөнгө, хүч шаардагддаг, за хоёрдугаарт газраас авхуулаад нэлээн асуудлууд байдаг учраас ер нь бол бага сургуулиуд нь дунд сургуулиудынхаа харьяа, ахлах сургуулиуд нь бол коллеж, их дээд сургуулиудынхаа төрөлжсөн ахлах сургуулийнхаа тогтолцоо руу явах ёстой юм байна аа гэж харж байгаа.

Ер нь 330 суманд 12 жилийн сургууль байна гэдэг бол энэ их л цамаан тогтолцоо юм байна лээ. Тэгээд цаашдаа бол 300 хүүхдээс доошоо хүүхдүүдтэй байгаа сургуулиуд, 100 хүүхдээс доошоо байгаа хүүхэдтэй сургуулиудыг бид нар нэг ээлжид шилжүүлэх, цаашдаа бол бид нар ерөнхийдөө сум дундын ахлах сургууль төлбөрөөр зохион байгуулах нь сургалтынхаа чанар болоод боловсролын салбарт хийгдэж байгаа хөрөнгө оруулалтын чанар, хүртээмжийн асуудлыг шинэчлэх нь зайлшгүй ийм шаардлага бас байгаа юм гэж харж байгаа.

Аймаг, нийслэлийн Засаг дарга нарт суурь боловсролын төлөвлөгөө боловсруулах гэж. Энэ бол Засаг захиргаа нэгжийн тухай хуулийн чиг үүргүүд орон нутаг руу шилжиж байгаа холбоотой заалтууд болов уу гэж бодож байна. Манай Төрийн нарийн бичгийн дарга энэ дээр онцгойлон хариулчхаарай. Яагаад энэ заалтууд орж байгаа. Энэ заалтын цаана ямар юу байгаа гэдгийг. Холимог бүлэг гэдгийг манай Ням-Очир дарга хариулчих уу, тийм ээ. Нэгжийн хуультай холбоотой, ер нь зарим төсвөө бүрдүүлдэг аймгууд чинь Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар цэцэрлэг, сургуулиа шийддэггүй. Өөрсдөө шийдээд явчихдаг шүү дээ. 7 аймаг байгаа. Улсын төсвийн хөрөнгө оруулалтыг шаарддаггүй, өөрсдөө хийдэг. Тэгэхээр тэр аймгууд дээр байгаа асуудлуудыг бид нар хэрэв барилга байгууламжийн хөрөнгө оруулалтын асуудлуудыг нэгдсэн маягаар шийдэх одоогийн тогтолцоогоор явах юм бол тэр чинь их ойлгомжгүй үлдэнэ.

Тийм учраас бол тэр эрхүүд нь нээлттэй үлдээд тэр нөгөө барилгын сургууль, цэцэрлэгийн суурь зардал болон урсгал зардал, их засвартай холбоотой асуудал нь бол нэгжийнхээ тухай хуулиар энэ орон нутагтаа шилжиж байгаа юм аа. За Батбаатар дарга тэр юуг хариулчих.

Г.Дамдинням: 2 дугаар микрофон өгөөрэй. Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Батбаатар

Д.Батбаатар: Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хуулиар бол орон нутгийн удирдлагад боловсролын салбар дээр хэрэгжүүлэх эрх үүргийг нь зааж өгсөн байгаа юм. За үндсэндээ Улсын төсвөөр баригдаж байгаа барилга, сургууль, цэцэрлэгийн барилгууд баригдаад дуусангуут бид тэр чигт нь орон нутагтаа шилжүүлж, хүлээлгэж өгөөд тэрнээс хойших бүх харилцаа нь орон нутгийн өмчийн харилцаагаар зохицуулагдаад явж байгаа юм.

Өөрөөр хэлбэл тэнд хийгдэх дараагийн засвар үйлчилгээ, тэнд авах арга хэмжээ, барилгын засвар үйлчилгээ байдаг юм уу тэр бүх арга хэмжээ нь орон нутаг. 28.9-д “Боловсролын байгууллагын барилга болон түүний засварын үйлчилгээг хариуцаж, сургалтын үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөлийг хангана” гэж.

Г.Дамдинням: Гишүүдийн асууж байгаа асуултыг бас тодорхой ойлгож хариулаач ээ. 1 дүгээр микрофон. Боловсролын дэд сайд Ганбаяр хариул.

Г.Ганбаяр: Баатарбилэг гишүүн энэ аймгийн боловсролын газрын байрыг л яриад байгаа юм. Одоо бол аймгийн боловсролын газрууд үндсэндээ яг өөрийн гэсэн бие даасан байр байхгүй. Зарим нь түрээсийн, зарим нь нэг байгууллагынхаа нэг давхар сууж байгаа. Уг нь бол аймгийн боловсролын газар яг төсвөөс бүгдийг нь нэгдсэн байдлаар 1 байртай болгоё гэсэн. Тэгээд төсөв дийлэхгүй боломжгүй гээд байгаа учраас энэ хууль дээр аймаг, нийслэлийн Засаг даргын бүрэн эрхэд аймгийн боловсролын газрыг байр, барилга байгууламжаар хангана л гэдэг ийм заалтыг л оруулж байгаа юм шүү. Шууд зардал бол хуучны хувьсах зардал гэсэн үг.

Г.Дамдинням: Дараачийн асуултад холимог бүлгийн тухай 3 дугаар микрофон. Ням-Очир дарга хариул.

Т.Ням-Очир: За Баатарбилэг гишүүний асуултад хариулъя. Ер нь хэд хэдэн үндэслэлүүд байгаа юм. Нэгдүгээрт ер нь хүүхдийн тооноос хамааруулаад сумын сургуулиудыг бид нар нэг ээлж рүү шилжүүлэх концепц зарчмыг нэлээдгүй барьж байгаа юм. Тэгээд 1.2-оос доош ээлжийн кофиденттэй бараг 286 сургууль байгаа. Энэний 204 нь сумын сургууль, 41 нь багийн сургууль, 41 нь аймаг, нийслэлд байгаа сургууль гээд байгаа. Хэрвээ цаашаа 1 ээлжид шилжих юм бол сургалтын төлөвлөгөө, хичээлээс гадуурх үйл ажиллагаа нэлээн тийм уян хатан зохицуулалтууд бий болно гэж харж байгаа юм.

Өөрөөр хэлбэл хүүхэд өглөө ирээд үдээс хойш 16 цаг гээд явлаа гэж бодоход энэ хооронд зөвхөн сургалтын төлөвлөгөөнд заавал судлах цагуудаас гадна хөгжүүлэх үйл ажиллагаанууд нэлээдгүй орж ирэх ийм харилцаа зохицуулалт үүснэ гэж харж байгаа.

Хоёрдугаарт нь ахлах ангийн сургалтын хөтөлбөрийг бид нар сонголттой болгох энэ бодлого концепцыг барьж байгаа. Тэгэхээр магадгүй тэр хүүхэд химийн хичээл сонгоод тэр сумын ч юм уу аймгийн сургууль дээр 10-12 дугаар ангид нь 30 хүүхэд химийн хичээл сонгосон бол 30 хүүхэд холимог бүлэг болоод нэг зохион байгуулалтад ороод явах ийм зохицуулалтууд бас нэлээдгүй үүсэж хэрэгцээ гарна гэж энэ хөтөлбөрийн хөгжлийн дараагийн чиг хандлага руу гарч байгаа.

Тэгэхээр ер нь 2024 оноос ахлах ангийн хөтөлбөр бүрэн сонголттой болно. За бага ангиуд дээр, дунд ангиуд дээр хөдөө сумдын сургуулиуд нэг ээлжид шилжихэд энэ зохицуулалт бас нэлээн тус болох юм гэсэн ийм байдлаар ингэж харж байгаа.

Г.Дамдинням: За цахимаар бас гишүүд байгаа. Хэдүүлээ дэгээрээ явчихъя. цахимаар Гомпилдоогийн Мөнхцэцэг гишүүн асуулт асууя

Г.Мөнхцэцэг: Сонсогдож байна уу? Сонсогдож байна уу?

Г.Дамдинням: Сонсогдож байна Мөнхцэцэг гишүүн ээ.

Г.Мөнхцэцэг: За Боловсролын цогц хууль орж ирж байгаа явдал цаг үеэ олсон л асуудал гэж ингэж бид бодож байгаа.Үе үеийн сайд нар бас л энэ дээр нэлээн олон удаа ажиллачихсан учраас бас харьцангуй нэлээн их тийм боловсрогдож орж ирж

байгаа гэж бодож, найдаж байгаа юм. Тэгээд хэд хэдэн асуулт байгаа юм. Ялангуяа боловсролын санхүүжилттэй холбоотой хөдөө орон нутагт гарж байгаа нэлээн их хүндрэлүүд байдаг. Энэ асуудлуудыг ярихгүй бол болохгүй нь ээ. Боловсролын ялгааг арилгана гэж байгаа. Санхүүжилт дээр хувьсах зардлын баримтаас харахаар цөөн хүүхдийн алслагдсан сургуулиудад багшлах боловсон хүчнүүд маш хомс байдаг. Тэгээд тэдний зардлын хувьд бас орон тоогоо их танаж байгаа. Тийм учраас энэ тал дээр ямар хуулийн заалт тусгасан бэ? Гэдгийг би асууя гэж бодсон юм байгаа юм. Өнөөдөр Монгол Улсад 330 сумын 109 нь 9 жилийн сургуультай байгаа. Бараг 10 мянга орчим хүүхэд сурч байгаа байх гэж бодож байна. Тэгээд бага санхүүжилтэд тааруулаад цөөн бүх ажиллуулдаг гэсэн үг л дээ. Тэгэхээр энэ үндсэндээ хөдөө орон нутагт байгаа энэ сургуулиудад 9 жилийн сургалттай сургуулиудад л 9 үндсэндээ 20 төрлийн хичээл үзэж байна гэж байхад энийг бас цөөхөн тооны багш 3-5 төрлийн хичээлийг нэг багш зааж байна гэсэн үг л дээ. Тэгэхээр үндсэндээ 10 мянган хүүхэдтэй гээд харьцуулаад бодох юм бол суурь шинжлэх ухааны хичээлийн нэг багш зааж байна гэдэг бол учир дутагдал үүсэж байна гэсэн үг л дээ. Тэгэхээр яг ийм зохицуулалт энэ хуульд ямар байдлаар туссан юм бэ гэдгийг асууя гэж бодсон юм.

Хоёрдугаарт боловсролын үнэлгээтэй холбоотой асуултууд байна. Ер нь боловсролын үнэлгээ, мониторинг хийх асуудлууд маш их бүрхэг тусгагдсан байна гэж би харж байгаа. Тэгэхээр боловсролын үндсэн гол тулгуур нь багш, мэдээж хөтөлбөр байгаа. Нэг сайд гарч ирээд л нэг хөтөлбөр хэрэгжүүлээд эхэлдэг. Тэгэхээр яг багшийг үнэлээд байдаг. Хөтөлбөрүүдээ ерөөсөө үнэлдэггүй. Тэгэхээр хөтөлбөрийг үнэлэх тал дээр энэ хуульд ямар.../минут дуусав/

Г.Дамдинням: Мөнхцэцэг гишүүн нэмэлт 1 минут авах уу? За Мөнхцэцэг асуултад Энх-Амгалан сайд хариулъя.

Л.Энх-Амгалан: Мөнхцэцэг гишүүн маань 3 асуултыг л тойроод ярьж байх шиг байна. Нэг нь бол боловсролын санхүүжилттэй холбоотой асуудал. Тэр тусмаа хөдөө хүн ам багатай сум, баг дээр ажиллаж байгаа сургуулиудын санхүүжилт. Багш нарын санхүүжилтийн асуудлууд ярьж байх шиг байна. Ерөнхийдөө бид нар энэ суурь санхүүжилт Мөнхбат гишүүн ээ. Ерөнхийдөө энэ суурь санхүүжилт хувьсах зардлын санхүүжилт гэдэг тогтолцоогоор бид нар сая хүртэл явж ирсэн. За тийм учраас энэ хувьсах зардлынхаа санхүүжилтийн аргачлалыг бид нар өөрчлөхөөс өөр арга байхгүй юм билээ. Яагаад гэх юм бол үнэхээр цаашдаа боловсролынхоо чанар, хүртээмжийн асуудлыг арай жаахан шинэ түвшинд чанараа хэмждэг, үр дүнгээр хэмждэг ийм болох тогтолцоо руу шилжүүлэх хамгийн гол арга бол ерөөсөө санхүүжилтээсээ л эхлэх ёстой юм байна лээ.

Тэгээд боловсролын салбарт ирж байгаа 1.7 их наядын бараг үндсэндээ 1 их наяд нь зөвхөн багш нарын цалинтай холбоотой асуудлууд. Гэтэл харамсалтай нь нөгөө хувьсах зардлаас санхүүжүүлж байгаа тэр цалинууд яг тэр сургуулийнх нь суурь зардлуудыг санхүүжүүлж байгаа. Энэ зардлууд нь ямар нэгэн тийм тухайн сургуульд ажиллаж байгаа багш нарын ажлын үр дүн, тухайн сургуульд сурч байгаа

суралцагчдын ахиц үр дүнтэй бол ямар ч холбоогүй ийм хувьсах зардлын аргачлалтай өнөөдрийг хүртэл явж ирж байгаа байхгүй юу.

Бараг үндсэндээ социализмын үеийн аргачлалтай явж байгаа гэж хэлж болно. Тийм учраас бид нар өнөөдөр энэ сургалтын хөтөлбөр, хичээл нэг бүрийн өртөгт суурилсан санхүүжилтүүдийг бий болгоё. Ер нь боловсролын яам өөрөө ширээ сандлаар хангадаг, компьютероор хангадаг энэ юмнаасаа л больё гэж байгаа юм. Яагаад гэвэл тухайн сургуулийнх нь тэр урсгал зардал дээр компьютер, тоног төхөөрөмжүүдийг нь элэгдлийн зардалд нь оруулаад өгчихье. Ингээд үүссэн элэгдлийн зардлаасаа магадгүй 3-5 жилийн.../минут дуусав/

Г.Дамдинням: Энх-Амгалан сайд үргэлжлүүлээд асуултад нь гүйцэд хариулчих.

Л.Энх-Амгалан: Ингээд багш нарын хүсдэг, сургуулиудын хүсдэг байгалийн ухааны лаборатори, компьютер, тоног төхөөрөмжийн асуудлуудаа сургууль нь өөрсдийнхөө элэгдлийн зардлын хуримтлалаар шийдээд явах энэ боломжууд нь байгаа гэж харж байгаа юм.

За хоёрдугаарт нь болбол тэр сургалтын чанарт суурилсан багшийн цалин урамшууллын тогтолцоог асуугаад байх шиг байна. Одоо энэ цаашдаа багшийнхаа ажлыг яг цэвэр үнэлдэг тэрэнд нь тохирсон цалин урамшууллын тогтолцоог бий болгохын тулд хамгийн гол нь энэ сурлагын ахиц дэвшлийн үнэлгээний тогтолцоо бий болгох. Ер нь манай Монгол Улс чинь өнөөдрийг хүртэл сургуулиудынхаа, багш нарынхаа, суралцагчдынхаа сурлага мөн одоо ажлын үр дүн, гүйцэтгэлийн үр дүнг ерөөсөө ийм үнэлдэг тогтолцоо ерөөсөө байхгүй юм байна лээ. Тийм учраас боловсролын үнэлгээний тогтолцоогоо бий болгоё, үндэснийхээ үнэлгээний тогтолцоог бий болгоё. За энэ дээрээ үндэслэж боловсролынхоо санхүүжилт үр дүнд чиглэсэн санхүүжилт рүү чиглэх зайлшгүй шаардлага байгаа. За би Мөнхцэцэг гишүүнтэй санал нэг байна. Ер нь сайд бүхэн ирчихээр хөтөлбөр солигддог нэг ийм зовлон Монгол улсад өнөөдөр байсан. Ер нь сүүлийн 20 хүрэхгүй жилийн хугацаанд маш том боловсролын салбарын хөтөлбөрийн шинэчлэлүүд хийгдсэн. Харамсалтай нь хөтөлбөр шинэчлэгдээд хөтөлбөрийг хэрэгжүүлэх ёстой багш нараа бэлдэж чаддаггүй учраас болоод өнөөдрийн энэ боловсролын салбарт үүсчихсэн байгаа энэ чанарын ялгаа, сурлагын хоцрогдлын асуудлууд үүссэн юм байна.

Ер нь Монголын боловсролын салбар хүүхдүүд маань бол ер нь олон жилийн турш хөтөлбөрийн шинэчлэлийн золиос болсон ийм л нөхцөл байдал өнөөдөр үүсчхээд байгаа шүү дээ. Хөтөлбөрүүд ойрхон ойрхон солигддог, Хөтөлбөр солихоор сурах бичиг солигддог. Тэрэндээ тохирсон багшийнхаа сургах арга зүйг хөгжүүлж, нэвтрүүлж чаддаггүй учраас Монголын боловсролын салбарт бол тодорхой хэмжээний хөтөлбөрийн хоцрогдол, сурлагын хүүхдүүдийн хоцрогдол багш нарын арга зүйн хоцрогдлууд үүссэн ийм нөхцөл байдлууд үүссэн байгаа учраас өнөөдрийн оруулж ирж байгаа энэ хууль дээр бол энэ хөтөлбөрийн шинэчлэлийн асуудлууд цаашдаа энэ боловсролын хөтөлбөр жаахан тогтвортой байх ёстой гэж байгаа юм. Хамгийн багадаа

бол 10-12 жилийн хугацаатай байх ёстой гэсэн энэ тогтолцоог л хуулиараа баталгаажуулж өгч байгаа юм.

Г.Дамдинням: Энх-Амгалан сайд түрүүн тэр Баатарбилэг гишүүний асуугаад байсан асуултыг гүйцэд хариулчхаач.

Л.Энх-Амгалан: За манай Баатарбилэг гишүүн маань ийм юм асуусан юм. За 12 жилийн тогтолцоонд шилжчих юм бол суурь боловсролын гэрчилгээ гэдэг ойлголт байхгүй биз дээ гэж байгаа юм. Энэ зөв байхгүй болно. Бүрэн дундын гэрчилгээ, 12 жилийнхээ гэрчилгээг авна. Гэхдээ сургуулиуд яагаад гэрчилгээ гэдэг тэр сургуулийн бүтэц,хэв шинжтэй холбоотой гэрчилгээ байдаг ойлголтууд гараад ирэв гэж асуугаад байх шиг байна л даа? Зөв л асуулт л даа. Тэгэхээр цаашдаа сургуулиуд, цэцэрлэг бага сургууль, дунд сургууль 1-9 дүгээр анги. Цаашдаа ахлах сургуулийн төрөлжсөн сургуулиуд гарах юм бол бага сургуульдаа сурсныг баталгаажуулах шаардлагатай шүү дээ. Аль сумын яг аль бага сургуулийг дүүргэсэн юм гэдгийг нь баталгаажуулах шаардлагатай. Тэгэхдээ боловсролын баталгаажуулалт биш. Сурсны тухайн сургуульд сурсан нь үнэн болсон гэсэн тодорхой баталгаажуулалт хэрэгтэй. Дунд сургуульд сурсан баталгаажуулалт хэрэгтэй. Тэгэхээр энэ чиглэлээр ийм баталгаажуулалтуудын асуудлуудыг л хэлж байгаа ийм л эрх зүйн зохицуулалт гэж ойлгож байгаа. Тэрнээс биш нэгэнт л 12 жилийн тогтолцоотой болж байгаа учраас зөвхөн 12 жил сурсан хүүхэд л бүрэн дундын гэрчилгээ авах ийм л тогтолцоо руу шилжиж байгаа юм. Энэ л зүйлийг асуугаад байна.

Г.Дамдинням: За Балжиннямын Баярсайхан гишүүн танхимаар асуулт асууна.

Б.Баярсайхан: За баярлалаа. Боловсролын багц хууль дээр яамны Төрийн нарийн бичгийн дарга байхдаа энэ хуулийн ажлын хэсгийг ахалж ажиллаж байсан. Энэ дээр СӨБ болон ерөнхий боловсролын тухай хуулийн зорилго зорилт дээр сайн зан чанартай иргэн бэлдэх гэдэг үг хасагдчихсан байна. Энэ үгийг яагаад хассан юм бэ? Бага насны хүүхдийн сэтгэл зүйн онцлог, ялангуяа зан чанарыг судалсан судалгаа хийгдээд энийг хасчихсан уу эсвэл яагаад хасчихсан бэ гэдэг асуудал байна. Энэ өндөр хөгжилтэй орнууд, ялангуяа бидний энэ улсын орнуудын дуурайгаад байгаа туршлагыг нь судлаад байгаа Скандинавын орнууд сайн зан чанартай иргэн бэлтгэх гэдэг дээр гол бодлогоо чиглүүлж байгаа. Энэ яагаад хуулиас хасагдчихав гэдэг 1 асуулт байна. За энэ зан чанарын судалгаа хийгдсэн үү? Сүүлийн 1.5 жилийн хугацаанд гэдэг асуудал байна. За энэ сайн зан чанартай, Монгол дотортой, Монгол хүн бэлтгэх гэдэг үг үсэг, өгүүлбэр энэ хуульд ерөөсөө харагдахгүй байна байгаа юу? Ерөнхий боловсролын хуулийн зорилт дээр ёс зүйтэй иргэн бэлдэх гэж. Бид нар хүүхдүүддээ сайн зан чанар төлөвшүүлэхгүйгээр ямар ёс зүй шаардах гээд байгаа юм бэ? Тэгээд энэ дээр хариулт авъя.

Хоёрдугаарт нь сэтгэл зүйчтэй болох ерөнхий боловсролын сургууль. Энэ бол маш чухал зорилт байж байгаа. Тэгэхлээр энэ сэтгэл зүйчтэй ялангуяа энэ сайн зан чанар төлөвшдөг энэ СӨБ болон 0-3 насанд сайн зан чанар төлөвшүүлэхэд сэтгэл

зүйчдээ яаж ашиглаж байгаа юм. Тэдэнтэйгээ яаж хамтарч ажиллаж байгаа юм бэ гэсэн асуудал байна. Тэгэхлээр зан чанар гэдэг бол зөвхөн 0-3 юм уу 3-5 биш шат шатандаа, нас насандаа хүүхэд.../минут дуусав/

Г.Дамдинням: Баярсайхан гишүүнд нэмэлт 1 минут.

Б.Баярсайхан: Тэгээд 0-3 насанд хүүхдүүдээ яаж сайн зан чанарт бэлтгэх юм гэдэг дээр эцэг эхчүүдэд мөн СӨБ-д өгөх зөвлөмжийг яамнаас гаргах уу? гэдэг асуулт байна. Мөн англи хэлийг үндсэн хэл болгоно гэсэн ийм зүйл явж байна. Тэгээд энэ орос хэл хасагдаж байгаа юм уу? Гэсэн энэ асуулт байна. За баярлалаа.

Г.Дамдинням: Энх-Амгалан сайд хариулъя.

Л.Энх-Амгалан: Баярсайхан гишүүн ээ бид нар энэ боловсролын хуулийнхаа зорилго зорилт гэдгийг шинээр тодорхойлж байгаа. Энийг шинээр тодорхойлж байгаа үндэслэл бол дэлхий нийтийн боловсролын чиг хандлага 21 дүгээр зуунд заавал эзэмших ёстой мэдлэг чадвар, ур чадвар, цогц чадамж гэж хэлж байгаа. Хоёрдугаарт 21 дүгээр зуунд амьдрах, боловсрол эзэмших, амьдралаа авч явах энэ зөв Монгол хүнийг яаж сургах вэ? Яаж боловсруулах вэ, яаж төлөвшүүлэх вэ гэдэг энэ зорилттой л уялдуулж байгаа юм.

Тэгэхээр зан чанар гэдэг бол зөвхөн нэг л асуудал. Тэгэхээр боловсролын алтан гурвалжин гэж байгаа шүү дээ. Мэдлэг, чадвар, хандлага. Хандлага буюу төлөвшил. Тийм учраас таны ярьж байгаа энэ зүйл бол төлөвшил илүү төлөвшил, хандлагатай холбоотой асуудал. Тэгэхээр өмнө нь бол манайх яг ингэж явж ирсэн боловсролын салбарын гол алдаа дутагдлууд бол илүү дандаа математикч хүүхдүүдээ бэлдэх гэж анхаарч байсан. Дандаа академик мэдлэг өгдөг. Гэтэл харамсалтай нь өнөөдөр яг өнөөдөр математикч хүн чухал уу? Эс үгүй бол зөв Монгол хүн чухал уу гэдэг л асуудал байгаа байхгүй юу. Тэгэхээр өнөөдөр сургуулийн өмнөх боловсрол, бага боловсролоор нь энэ нь хамгийн зөв төлөвшлүүдийг олгох ийм зайлшгүй шаардлага байна гэж харж байгаа. Энийг бид нар юунаас нь гаргаж харж байгаа вэ гэхээр өнөөдөр бид нарын ярьж байгаа үндэсний мэргэшлийн шаталсан бүтэц гэдэг англиар бол National qualification frame work гэдэг. Энэ зүйлээ бид нар их орхисон юм байна лээ. Тийм учраас насан туршид нь сургах энэ насан туршийн суралцахуй гэдэг нэгдүгээрт зарчим барих, хоёрдугаарт бол 10 түвшинд нь 10 түвшин гаргаж ирээд яг сургуулийн өмнөх боловсрол дээр бид нар ямар мэдлэг, ур чадваруудыг олгох ёстой юм.

Г.Дамдинням: За Энх-Амгалан сайдад нэмээд минут өгье.

Л.Энх-Амгалан: Тийм учраас бол мэдлэг, чадвар, төлөвшил гэдэг энэ гурвууланг нь цогц чадамж эзэмшсэн зөв Монгол хүнийг бэлтгэх нь бол Монгол Улсын боловсролын системийн зорилго, зорилт байна гэж тодорхойлж байгаа юм.

Хоёрдугаар асуудал бол сэтгэл зүйч бол зайлшгүй чухал сургуульд ажиллах. Ер нь энэ санал санаачилгыг манай яам гаргаад өнөөдөр Монголд бэлтгэгдчихсэн байгаа,

төгсгөж байгаа сэтгэл зүйчдийнхээ судалгааг хийгээд, тэгээд Монголын сэтгэл зүйчдийн холбоотой хамтраад ер нь энэ жилийн ЭЕШалгалт өгч байгаа 40 мянган хүүхэд дээ сэтгэл зүйн зөвлөгөө өгч эхэлсэн. За бүх аймгийнхаа Засаг дарга нартай хурал хийж ерөнхийдөө энэ боломжтой байгаа төсөвтэй, төсвийн өөрөө бүрдүүлдэг аймгууд нь сургуулиуд дээрээ сэтгэл зүйчээ шийдэх энэ алхмуудыг бас хийж байна. Ер нь цаашдаа зөв Монгол хүүхдийг төлөвшүүлэх энэ асуудалд нэлээн тооцоотой, судалгаатай, үндэслэлтэй хандах ёстой юм байна лээ.

Тэр сэтгэлийн хөөрлөөр биш. Ганцхан сэтгэл зүйч шийдсэнээр энэ асуудал шийдэхгүй. Тэгэхээр боловсролын хүрээлэнгээ бид нар чадавхжуулах зайлшгүй шаардлага байна. Багшийн их сургуулиа чадавхжуулах зайлшгүй шаардлага байна. Боловсролынхоо үнэлгээний төвийг чадавхжуулах зайлшгүй шаардлага байна. Багшийн мэргэжил дээшлүүлэх институт гэсэн энэ 4 том байгууллагууд институцээ чадавхжуулж байж яг Монгол хүүхдийн нас, бие онцлогт тохирсон сэтгэл зүйн ямархуу чадамжуудыг аль насанд нь эзэмшүүлэх ёстой гэдэг зүйлийг л тодорхойлж байж. Энэ хууль батлагдаж гарсны дараа хөтөлбөрийн шинэчлэлүүдээ энэнтэйгээ уялдуулж л хийх ёстой. Аль насанд нь ямар чадвар, ямар мэдлэг, ямар төлөвшлүүдийг бий болгох вэ гэдэг зүйл бол эргээд энэ хөтөлбөрийнхөө шинэчлэлүүдээр хийгдэнэ. Ямар ч байсан одоогийн сургуулийн өмнөх боловсрол бага боловсролд байгаа, авч чадахгүй байгаа, хүүхдүүдийнхээ авч чадахгүй байгаа төлөвшил хандлага, мэдлэг, чадвартай холбоотой энэ хөтөлбөрүүд бол энэ шинэчлэлийн хүрээнд бас хийгдэнэ л гэж харж байгаа юм.

Англи хэл бол бид нар англи хэлийг 2 дахь хэл болгож дэлхийн иргэн бэлдэнэ гэж манай Засгийн газрын мөрийн хөтөлбөрт туссан байгаа. Тийм учраас англи хэлийг сурах биш зарим хичээлийг англиар үзэх ийм л боломжуудыг бүрдүүлэх ёстой юм байна лээ. Тэгж байж англи хэл бол хоёрдогч хэл болно. Тийм учраас өнөөдөр үндсэн гадаад хэл нь англи хэл байна гэж энэ хуульд тодорхойлж, үндсэн гадаад хэл нь тийм учраас төрөлх хэл дээрээ сурах ёстой. Хоёрдугаарт тэр хүүхдүүд бол яг тэр нөгөө англи хэлээр үзэх ёстой байгалийн ухааны хичээлүүд чинь тодорхой хэмжээнд дунд, ахлах ангиасаа тодорхой л хэлбэрээр үзэж эхэлнэ. Тийм учраас тэр нь бол англи хэл байна. Магадгүй цаашдаа хүүхэд юу гэдэг юм, орос хэл гэдэг юм уу, франц хэл гэдэг юм уу, хятад хэл гэдэг юм уу, солонгос хэл бол тэр өөрсдийнхөө ахлах сургуулийнхаа хэмжээнд 10, 11, 12 дугаар анги дээр бол сонгоноор үзээд явах ийм бололцоотой байгаа.

Хүүхдүүдийг үүрэгжүүлж байгаа гол асуудал бол эх хэлээрээ сурна. Хоёрдугаарт эх хэл дээр нэмэх нь англи хэл бол үндсэн гадаад хэл нь англи хэл байна л гэж тодорхойлж өгч байгаа юм.

Г.Дамдинням: Тэр судалгаа гээд асуугаад байна.

Л.Энх-Амгалан: Зан чанарын судалгаа хийгдэж байна уу гэж . Зан чанарын судалгааг боловсролынхоо хүрээлэнтэй хамтарч ер нь манай энэ боловсролын

хүрээлэн чинь 5 жил тутам яг хүүхдүүдийн зан төлөв, бие бялдрын суурь судалгаануудаас хүүхдийн хөгжлийн асуудлаар суурь судалгаа нь хийгддэг юм байна лээ. Харамсалтай нь боловсролын хүрээлэн дээр судалгааг хийдэг. Тэр судалгаан дээр үндэслэсэн. Тэр зөвлөмжүүдийг энэ бодлого хийж байгаа яам нь багш бэлдэж байгаа багшийн их сургууль нь багшаа давтан бэлдэж байгаа багшийн мэргэжлээ эхлүүлэх институт, багшийн болон хүүхдийн сурлагын ахиц дэвшлийг үнэлэх ёстой үнэлгээний байгууллагууд нь хоорондоо хийсэн судалгаагаа зөв ашиглаж, бодлого болгож, хөтөлбөр болгож хэрэгжүүлэх тал дээр л хамтын сан.../минут дуусав/

Г.Дамдинням: Сая танхимаар асуучихсан. Энэ Телуханы Аубакир гишүүнийг асуулт асуух жагсаалтад оруулаарай онлайнаар. Ж.Мөнхбат гишүүн асуулт асууна.

Ж.Мөнхбат: Энэ их том хууль. Чухал хариуцлагатай хууль. Манай Боловсролын байнгын хороо өнгөрсөн жилээс авхуулаад Монгол Улсын 21 аймаг, 330 сум, 9 дүүрэгт бүх 152 хороо, үүрийн бүх сургуулиудтай теле уулзалт хийж, бүх багш нарынхаа саналыг авч бид нар чинь ер нь манай Байнгын хорооны гишүүд, би тухайн үед Байнгын хорооны дарга байсан санагдаж байна. Бараг 10-аад удаагийн хэлэлцүүлгийг хийсэн. Ийм бүх багш нарынхаа санал бодлыг сурган хүмүүжүүлэгчийн саналыг анх удаа улсын үндэсний хэмжээнд хийж байж оруулж ирж байгаа хууль.

Гэхдээ энэ хууль бол их орой орж ирж байна. Боловсролын яамныхаа уг нь 4, 5 сард орж ирээд эртхэн шиг хэлэлцүүлэгт ороод явсан. Одоо 7 хоногийн дараа чуулган завсарлах гэж байна. Бид нар энэ том хуулийг 2-хон минутад асуугаад хариулаад, явуулах нөхцөл рүү л явж байна л даа. Нөгөө багш нарын минь асуугаад байсан тэтгэврийн насыг наашлуулна 55, 50 болгоно гэсэн асуудлууд юу болсон бэ, яаж тусалсан бэ? Маш олон багш нар асуусан хот, хөдөөгийн ялгааг арилгана гэсэн юу болсон бэ? Өнөөдөр орон нутагт байгаа багш нарын хоцрогдлын асуудал байж байгаа. Тэгээд энэ асуудал хөдөө, орон нутагт алслагдсан орон нутагт ажиллаж байгаа багш нарыг ямар хөшүүрэг, дэмжлэгээр дэмжиж байгаа вэ? Хөдөөгийн боловсролын түвшингийн зөрүү яаж арилгаж байгаа вэ? За дээрээс нь тэр сум дундын сургууль гэж байна. За энэ бол их хэцүү асуудал шүү. Өнөөдөр суманд байгаа ерөнхий боловсролын сургуулийг татан буулгаад 2-3, 4, 5 сум дундаа нэг суманд очиж ахлах ангиа арван 11, 12-оо төгсдөг болно гэвэл наадах чинь бид нар хөдөөний тойргоос сонгогдсон гишүүд очих нүүргүй болно шүү. Энэ жоохон амьдралтай юмыг бид нар хөрсөн дээр нь бууж ярих хэрэгтэй. Нэгдүгээрт өнөөдөр.../минут дуусав/

Г.Дамдинням: Мөнхбат гишүүн 1 минут.

Ж.Мөнхбат: Иийм юмыг анхаараач. Хоёрдугаарт энэ 44.10.1 чинь ямар ойлгомжгүй юм бэ? Лизинг болон түрээсээр тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл жил болгон төрийн бус байгууллагаас сургууль авна гэх юм. Энэ баахан дараа нь хэл ам болж, захирлуудынх нь танил талын баахан төрийн бус байгууллагуудын шахаа хийсэн, хийгээгүй гээд баахан хүн шоронд явах юм болох вий. Дараагийн нэг юм бол дээд боловсролын хууль дээр социализмын юмнаас арилмаар байна аа. Би төрийн

сургууль төгссөн хүн. Гэхдээ энэ төрийн сургуулиудыг монопол болгох хууль оруулж ирсэн байна шүү. Гадаад тэр Харвард, Стенфорд, Оксфорд , Ил гээд бүгдээрээ л хувийн сургууль байгаа. Кембриж. Гэтэл өнөөдөр төрийн сургуулиуд л монопол байна гэдэг дээд боловсролын хууль оруулж ирж байна шүү дээ. Тэр 5.6, 5.3 дээр тэр үндэсний гэдэг юм төрийн бус байгууллага дээр зөндөө л хэрэглэгддэг. Энэ 2 сургуулийн маргааныг хуульчилж оруулж ир.

Г.Дамдинням: За Мөнхбат гишүүний асуултад Энх-Амгалан сайд.

Л.Энх-Амгалан: Мөнхбат гишүүндээ их талархаж байгаа. Манай Мөнхбат гишүү нь бол Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга. Боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны дарга байхдаа энэ хуулийн хэлэлцүүлгийг орон даяар хэлэлцүүлэхэд маш их санал санаачилга гаргаж ажилласан гишүүн, Байнгын хороон дарга талархал илэрхийлэх ёстой гэж би ойлгож байгаа юм.

Тэр тусмаа Байнгын хорооныхоо гишүүдийг хүртэл аймгууд дээр хуваарилуулаад энэ хуулийн хэлэлцүүлэг маш сайн хийсэн. Хууль их оройтсон байна гэж байна. Энэ дээр бол тантай санал нийлэхгүй байна. Бид нар дутуу хууль өргөн барьж болохгүй. Тийм учраас Боловсрол, шинжлэх ухааны сайдаар томилогдоод Засгийн газраас өргөн барихаар бэлтгэгдчихсэн байсан хуулийг авч бид нар ажилласан. За ингээд ажилласнаараа бид нар дутуу хуулийг яг юу юуг нь дутуу байсан юм бэ гэдгийг гүйцээсэн хэд хэдэн 7, 8 зарчмын концепцын шинж чанартай өөрчлөлтүүдийг бид нар хийж чадсан.

Нэгдүгээрт нь мэргэжлийн үндэсний шаталсан бүтэц гэдэг шинэ тогтолцоо. Бид нарын хамгийн их хүсэж байсан, хүлээж байсан, хамгийн их дутагдаж байсан. Энэ дээрээ тохируулж бид нар боловсролынхоо түвшин боловсролынхоо тогтолцоог энэ дээрээ түшиглэж хийсэн. Энэ бол хамгийн амин чухал асуудал. Бараг энийг хийхгүйгээр боловсролын хууль батлаад хэрэггүй. Энэ амин чухал асуудал энийг орхигдуулсан байсан.

Хоёрдугаарт үнэлгээний тогтолцооны асуудлуудыг орхигдуулсан байсан үнэлгээний тогтолцооны асуудлыг.

Гуравдугаарт чанарын баталгаажуулалтын асуудлуудыг орхигдуулсан байсан.

Дөрөвдүгээрт санхүүжилтийн зарчмуудыг яг ямар зарчмаар санхүүжүүлж явах юм? Энэ олон жил ярьсан багшийн сурган хүмүүжүүлэгчийн үндсэн цалин, нэмэгдэл цалин, цалин урамшууллын асуудал, нийгмийн баталгааны асуудал маш тодорхойгүй зүйлүүд байсан.

Тавдугаарт англи хэлний асуудлууд тодорхойгүй байсан.

Зургадугаарт болбол энэ сургуулийн хэв шинжийн асуудлууд тодорхойгүй байсан.

Долдугаарт энэ хөрөнгө оруулалтын зарчим боловсролын салбар дээр ямар зарчмууд явах ёстой байсан юм бэ гэдэг асуудал. Ийм олон зүйлүүдийг.../минут дуусав/

Г.Дамдинням: Тэгэхээр хуулийн төсөл бол Мөнхбат даргын үед Байнгын хороон дээр хэлэлцэгдээд явж байсан хууль засаг дээрээсээ буцаад, үзэл баримтлалын өөрчлөлт оруулаад, буцаж засгаар ороод тэгээд өргөн баригдаж байгаа. Өөрөөр хэлбэл хуулийн нэр томъёоллоороо бол цоо шинээр шинэчилж орж ирж байна аа л гэсэн үг. Ийм хууль явж байгаа. Одоо Байнгын хороогоор энэ хуулийг хэлэлцэж байна. Тэгээд хэлэлцэж байгаа учраас би хэлэлцэх эсэхээ өнөөдөр шийдээд дараа нь чуулганаар оруулаад тэгээд энэ зун, намрын турш улс орон даяар Байнгын хорооноос өргөн хэмжээний хэлэлцүүлгийг дахин зохион байгуулна.

Бүх аймгуудаар, сумуудаар, сургуулиудаас саналуудыг нь авна. Ингээд бүх оролцогч талуудын саналыг авна. Ингэж байж нийгмийн том өөрчлөлтийн шинж чанартай энэ хуулийг бид нар зөвшилцөлд оруулж байж авч гарна. Тэгэхээр үүнд та бүхэн бас бэлтгэлтэй, бодолтой байгаарай. Одоо Мөнхбат гишүүний асуултад гүйцээж хариулах ажлын хэсгийн гишүүдээс. Энх-Амгалан сайд.

Л.Энх-Амгалан: Мөнхбат гишүүний асуултад хариулахад дор хаяж 15 минутаас хэрэгтэй. Тэгэхээр тэтгэврийн насны асуудлуудыг яг одоогийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа Хөдөлмөрийн хуулийнхаа хүрээнд л зохицуулалтаар орж ирсэн. Манай багш нар олон жил нөгөө малчидтай барьцаж 5 насаар тэтгэвэрт гаргах асуудал ярьдаг юм. За энэ бол буруу. Энэ бол буруу. Юугаараа буруу гэвэл ер нь энэ багшийн хөдөлмөрийн үлэмж, нийгмийн хамгааллын асуудлууд, баталгааны асуудлуудыг бид нар зөв схемээр, зөв тогтолцоогоор хийж чадах юм бол багш нар тэгж эр тэтгэвэрт гаръя гэж хэлэхгүй. Ер нь бол бид нарын гол зүйл бол бусад улс орнуудад байдаг багш нарын хувийн тэтгэврийн сангийн тогтолцоог оруулж ирье гэдэг ийм хувилбаруудыг судалсан юм. Харамсалтай нь бол Засгийн газар дээр Сангийн яамны дэмжлэг авч чадаагүй. Хуулийн хэлэлцүүлгийн үед бол цаашдаа багш нар нийгмийн даатгалынхаа сангаас тэтгэвэр, тэтгэмж авахаас гадна өөрийнхөө мэргэжлийн онцлогоос шалтгаалж багш нарын хувийн тэтгэврийн сангийн тогтолцоо руу, хуримтлалын тогтолцоо руу орох ийм зайлшгүй шаардлага өнөөдөр байгаа гэж харж байгаа. Хэрвээ бид нар энэ тогтолцоог бий болгож чадах юм бол манай багш нар өнөөдөр 5 насаар тэтгэвэрт гаргая гэж уралддаг ийм зүйл өнөөдөр байхгүй болно. Яагаад гэвэл өнөөдөр багш нар яагаад эрт тэтгэвэрт гарах гээд хүсээд байна вэ гэхээр өнөөдөр багш нарын ачаалал их байна. Ажиллаж байгаа орчин өдөр, шөнө шиг ялгаатай байна. Тийм учраас өнөөдөр үр дүнд чиглэсэн санхүүжилтийн энэ тогтолцоогоо бид нар бий болгож чадах юм бол багш нар маань удаан хугацаанд тогтвор суурьшилтай ажиллах эдийн засгийн хөшүүрэг сонирхлууд нь бий болно гэж харж байгаа.

Хот, хөдөөгийн ялгааг л арилгая гэж бодож байгаа шүү дээ. Боловсролын салбарын шинэчлэлийн өөрчлөлт бол ерөөсөө хот, хөдөөгийн ялааг л арилгая гэж байгаа юм. Тэр хувьсах зардлын аргачлал гэдэг бол хөдөөгийн сургуулиуд бага хувьсах зардал авдаг биш, илүү их зардлууд, хувьсах зардлууд авдаг. Энэ нь бол илүү

сургалтынхаа орчин, багш нарынхаа сурах арга барилыг дээшлүүлэх, сурагчдын сурлагын ахиц дэвшлүүдийг дээшлүүлэх, хөдөө, хотын боловсролын ялгааг арилгах энэ концепцууд хуулиараа орж ирж байгаа Мөнхбат гишүүн ээ.

Ерөнхий боловсролын суман дээр байгаа сургуулиудыг татан буулгана гэж байхгүй ээ. Энэ хууль бол 2025 оноос бодитоор хэрэгжиж эхэлнэ. 2025 оноос. Цаашдаа бид нар сургуулиудаа, ахлах сургуулиудаа төрөлжсөн хэлбэрээр ингээд байгуулах ийм хэрэгцээ шаардлагууд өнөөдөр үүсэж байна. Цаашдаа бид нар энэ боловсролын салбарт хийж байгаа шаардлагатай байгаа цэцэрлэг, сургуулиудыг газар зүйн мэдээллийн систем буюу тухайн орон нутгийн хүн ам, эрэлт хэрэгцээ үүссэн ийм хэрэгцээ шаардлага дээр үүссэн ийм хөрөнгө оруулалтын бодлогуудын зарчмуудыг авч явна гэдэг асуудал.

За нөгөө талаараа бол энэ сургуулиудын төрийн өмчит их дээд сургуулиудыг монопол болгох хууль оруулж ирж байна гэж байна. Энэ үгүй. Өнөөдөр Монголд байгаа их, дээд сургуулиудыг аль болохоор чанаржуулах эрх зүйн орчнуудыг нь сайжруулж байгаа. Өнөөдөр 88 их, дээд сургууль өнөөдөр Монгол улсад байгаа. 147 мянган хүүхэд суралцаж байна. Харамсалтай нь хүүхдүүд их, дээд сургуулиудаа төгсөөд тэгээд ажлын байргүй болчихдог ийм өнөөдөр гашуун зовлон Монголчуудын нуруун дээр байна. Тийм учраас цаашдаа энэ дээд сургуулийг их сургууль болгох асуудлыг сайд шийддэг. Сайдын үзэмжээр шийддэг болохыг л больё гэж байгаа юм. Зарим нь ерөөсөө ер нь Монгол улс чинь ганцхан дээд боловсролын тогтолцоотой шүү дээ. Ер нь бол коллеж, их сургууль гэдэг graduate, under graduate гэдэг ийм л тогтолцоо байдаг болохоос биш манайх шиг дээд сургуулиудыг ийм ойлгомжгүй коллеж, дээд сургууль, их сургууль гэдэг ийм ойлгомжгүй статустай улс орон ерөөсөө байхгүй байхгүй юу. Тэгэхээр бид нарын хүсэж байгаа зүйл болбол их сургууль их сургууль шиг их сургууль байна. Коллеж нь коллеж шиг коллеж бай гэж байгаа.

Өнөөдөр бид нарын энэ орж ирж байгаа хуулиуд дээр одоогийн байгаа их сургуулиуд дээр тодорхой шалгууруудыг өсгөж байгаа. Тэр бакалаврын сургалтын тоо, докторын сургалтын тоо, нийт багшид эзэлж байгаа.../минут дуусав/

Г.Дамдинням: За одоо танхимаар Учрал гишүүн асуулт асууна.

Н.Учрал: За Энх-Амгалан сайд маш хурдан хугацаанд боловсролын суурь хуулийг өргөн бариад оруулж ирж байгаа явдалд бол маш их талархаж байна. Гэхдээ надад 1 асуулт байгаа юм. Ер нь дэлхийн боловсролтой эн зэрэгцэж явъя гэх юм бол хоцрохгүй явъя гэх юм бол бид нар дэлхийн стандарт, чанарын баталгаажуулалтаас хоцрох ёсгүй л дээ. Дагах ёстой. Тэгэхээр PISA /Programme for International Student Assessment/ хэрэгжүүлнэ, оюуны мэдлийн практик хэрэглэх чадвар гэсэн энэ тестийг 12 настай хүүхдүүдийн дунд авна гэж яриад байгааг нь бодохоор европын боловсролын тогтолцоогоор явах гээд байгаа юм шиг. Кембриж-ийн хөтөлбөр хэрэггүй. IGCSE /International General Certificate of Secondary Education/ авахгүй үндэсний онцлог, чухал, хүмүүнлэгийн хууль гээд санаачлаад яваад байгаа юмыг нь

бодохоор Европын боловсрол хэрэггүй ч юм шиг. Тэгээд дээд сургуулиуддаа болохоор Америкийн хөтөлбөрийн магадлан итгэмжлэлд ор гээд боловсролын яам нь шаардаад байдгийг нь бодохоор барууны боловсролоор явах гээд байгаа ч юм шиг. Ангиллаа хийж байгаа байдлыг нь харахаар Европын загвар classification хийх гээд байгааг нь харахаар бас европ руу явах гээд байгаа юм уу гэж бодох юм. Тэгээд заримдаа сайдын тайлбар дээр дээд сургууль гэж ойлголт байхгүй. Их сургууль, коллежоор явна гэхээр нөгөө Карнегийн ангилал гээд байдаг л даа. Тэрүүгээр явах гээд байгааг бодохоор европ биш ч юм шиг. Тэгэхээр би юу гэж асуух гэж байна вэ гэхээр Монголын боловсрол ер нь дэлхийн аль загвараар явах гээд байна вэ? Эхлээд энийгээ ярья. Тэгэхгүй хаашаа явахаа мэдэхгүй, яаж явахаа яриад үр дүн байхгүй. Зорилго бол аргаа зөвтгөдөггүй юм. Зорилго бол зөв байна. Гэхдээ аргыг хэзээ ч зөвлөхгүй.

Хоёрт дээд сургууль судалгаанд суурилж сургалт явуулдаг. Агуулга нь бол. Их сургууль дотор бол сургалтын, судалгааны гэж 2 их сургуулийн ангилал байгаа шүү дээ. 2 асар том ялгаатай. Сүүлд хэрвээ ингэж тавигдах шаардлага хийх гэж байгаа бол их сургууль дотор судалгааны, сургалтын гэж ангилаад дотор нь ангилаад тавьж өг.

Г.Дамдинням: За учрал гишүүн 1 минут.

Н.Учрал: Тэр судалгааны их сургуулийн шаардлага судалгаа, сургалтын их сургуулийн шаардлага чинь өөр болж таарч байгаа юм. За энэ хууль дээр дээд боловсролын хуульд тэр коллежийг дипломын сургалт явуулдаг дээд сургуульд байна гэж заасан. Дипломын сургалт явуулдаг дээд сургууль дэлхийд байхгүй. Дипломын сургалтыг зөвхөн европт бол 1 өөр, барууны орнууд бол өөр. Тэгэхээр наадах чинь болбол ойлгомжгүй зүйл. Дээд боловсролын хуульд зохимжгүй.

Хоёр. Сургалтын үйлдвэрлэлийн байгууллага юм гэж нэг ийм томъёолол оруулж байгаа. Дээд боловсролын хуульд коллежийг, сургалт үйлдвэрлэлийн байгууллага гэж оруулж болохгүй. Сургалт үйлдвэрлэлийн байгууллага гэж ер нь ямар байгууллага хэлээд байна вэ? Ямар байгууллага хэлээд байгааг нь бас ойлгохгүй байна.

Г.Дамдинням: За Учрал гишүүний асуултад Энх-Амгалан сайд хариулъя.

Л.Энх-Амгалан: Монголын боловсрол ер нь ямар загвараар явах гээд байна вэ гэж. Монголын боловсрол бол энэ өргөн барьж байгаа хуулиар бол дэлхийн боловсролын чиг хандлагад нийцсэн, Монголын хөгжлийнхөө онцлогт тулгуурласан, эрэлт хэрэгцээнд нийцсэн ийм л загвараар явах ёстой гэж ойлгож байгаа юм. Тэрнээс биш гаднаас кембержийг 100 хувь хуулчихъя, тэр IB /International Baccalaureate/ гэдэг хөтөлбөрийг нь 100 хувь хуулчихъя эсвэл турк сургуулийн загвараар явъя гэдэг ийм зүйл ерөөсөө байж болохгүй л гэж байгаа юм. Монголын боловсрол бол Монголын боловсролын загвараар л явах ёстой. Тэрнээс биш юу гэдэг юм. Бид нар 21 дүгээр зуунд англи хэлтэй, Монгол хэлээрээ ярьж чаддаггүй ийм Монгол иргэн бэлдэж болохгүй шүү дээ. Тэгэхээр 21 дүгээр зууны мэдлэг, ур чадвар, шаардлагатай мэдлэг, ямар мэдлэг, ур чадвар шаардлагатай вэ гэдгийг чинь угаасаа ингээд UNESCO болон Дэлхийн Эдийн засгийн Форумаас жил бүхэн зарлаад ер нь бол мэдлэгээсээ илүү

чадвар нь төлөвшил нь хувь хүнийх нь төлөвшлүүд нь их чухал юм байна. IQ, EQ гэдэг 2 юм чинь яг балансаараа бие биеийгээ авч явах ёстой юм байна. Тэр сэтгэл зүрхний боловсрол гэдэг чинь хэрэгтэй юм байна гэдэг нэг ийм концепц нөгөө цогц чадамж гэдэг нь мэдлэг чадвар, хандлага, төлөвшил гэсэн 3 зүйлийн цогцоор 3 зүйл бий болж байж цогц чадамж эзэмшсэн иргэнийг бүртгэх ийм л тогтолцоог бий болгохыг зорьж байгаа юм.

Тэгэхээр юу юугүй бид нар чинь өөрсдөө шинэ дугуй бүтээх гээд хэрэггүй байхгүй юу. Бид нарт ерөөсөө энэ боловсролын чанарын үнэлгээний энэ загвар чинь ерөөсөө бид нарт байхгүй шүү дээ. Бид нар хэн нэгэн газраас суралцах ёстой. Бид нар Кембрижийн сайн зүйлийг нь авах ёстой. PISA-ийн үнэлгээний сайн зүйлүүдийг бид нар авах ёстой. Тэгэхгүй бол зүгээр манай боловсролын салбарт орж ирж байгаа энэ шинэлэг зүйлүүдийг зүгээр хэсэг цөөн элитүүдийн хийж байгаа, тэр элитүүдэд зориулж хийж байгаа ийм зүйл гэж бид нар ерөөсөө болохгүй юм байна лээ.

Г.Дамдинням: Хассуурийн Ганхуяг гишүүнийг асуултад оруулчих. Хоёрдугаарт Г.Мөнхцэцэг гишүүн түрүүн техникийн саатлаас болоод нэмэлт асуултаа асууж чадаагүй юм байна лээ. Тэрийг нь дараа нь оруулна шүү. Тэгээд одоо хэнээс Энх-Амгалан сайд үргэлжлүүлээд хариултаа гүйцээчих.

Л.Энх-Амгалан: Тэгэхээр Учрал гишүүний энэ судалгааны их сургууль гэдэг бие даасан хууль байх хэрэггүй гэж бас би тантай бас санал нэг байгаа юм. Яах вэ, энэ нь Засгийн газраар бэлдэхдээ 4 хуулийг бэлдчихсэн учраас энэ судалгааны их сургууль бие даасан хуулийн гэдгээрээ гараад ирсэн. Одоо хуулийн хэлэлцүүлгийн үед бол бид нар Дээд боловсролынхоо хууль дээр Судалгааны их сургууль гэдгийг хийгээд өгчихье. Таны яриад байгаа Судалгааны их сургууль байх нь Интрепренёр их сургууль байх юм уу гэдэг энэ зүйлүүд ангиллуудыг энэ хэлэлцүүлгээр тодорхой болоод энэ чинь их онолын том маргаан юм байна лээ л дээ. Алийг нь Интрепренёр их сургууль гэх үү. Тэр нь манай их, дээд сургуулиудын аль нь энтрепренёр байх юм. Аль нь одоо судалгааны их сургуулиуд байх юм гэдэг чинь цэвэр энэ хөгжлийн асуудлууд л байгаад байгаа юм байна лээ. Энийг чинь яг үндсэндээ яг энэ чиглэлээр ажиллаж байгаа 8 эрдэмтэд, судлаачдын ажлын хэсэг гаргаад маш олон судалгаанууд хийгдсэн. Өнөөдөр энэ сая номууд ирсэн үү? Энэ бүх гишүүдэд яг энэ боловсролын хуулийн шинэчлэлтэй холбоотой 8 ажлын хэсгийн тайланг 2 боть ном болгоод бүх Байнгын хорооныхоо гишүүдэд тараах юм. Энэ судалгаан дээр гарсан их, дээд сургуулиудын ангилал, цаашид тавих шалгуурууд, хөгжлийнхөө аль түвшинд нь ямар хэлбэрээр явах юм гэдэг зүйлүүдийг л бид нар арай жаахан ойлгомжтой болгох гэж л оролдсон л нэг ийм л зүйл байгаа байхгүй юу.

Ер нь тэгээд цаашдаа бол энэ их сургууль гэж байх юм бол дан ганц сургалтаар амь зогоодог окутнуудынхаа тооны хойноос хөөцөлддөг, зөвхөн сургалтын төлбөр нь өнөөдөр орлогынх нь эх үүсвэр байдаг ийм их сургууль гэж байдаггүй л юм би лээ. Цаашдаа сургалт нь байдаг, судалгаа нь байдаг. Тэрэндээ инновац болоод зах зээл

рүүгээ гардаг ийм л амьд бүтэц, амьд организмд энэ судалгааны их сургууль буюу их, дээд сургуулиуд нь ийм л байх ёстой л гэж ойлгож байгаа шүү дээ.

Харин тэр магадлан итгэмжлэлтэй холбоотой асуудал дээр бол магадлан итгэмжлэх, энэ дээд боловсролын ангилалтай холбоотой асуудал. Тэр дээд боловсрол нь нөгөө яагаад дипломын сургалт хийх ёстой юм бэ гэдэг асуудал дээр манай Должин дарга хариулчих. Дээд боловсролын газрын дарга. Яг ялгаа заагийг нь.

Г.Дамдинням: Ажлын хэсгийн гишүүн, Дээд боловсролын газрын дарга Должин дарга. 3 дугаар микрофон хариулаарай.

С.Должин: Дээд боловсролын их, дээд сургуулиудын ангиллыг бид нар шууд бол өөрсдөө ангилаагүй. Энэ дээр тодорхой судалгаан дээр хийсэн. Энэ ангиллыг нь Боловсрол, шинжлэх ухааны яамны сайдын 2010 оны 26 тоот тушаалаар дээд боловсролын сургалтын байгууллагын ангилал тогтоох журам батлагдсан байгаа. Өнөөдрийг хүртэл энэ журам нь бол мөрдөгдөж байсан. За бид нар бол коллеж. Дээд сургууль, Их сургуулийн ангиллыг болоод тодорхой харьцуулаад хийж үзэхэд мэдээж бол аль ч манай Монгол Улсын хэмжээнд их, дээд сургууль нийтдээ 88 сургууль байгаа. Энэ ангиллыг авч ангиллыг аль ч ангиллаар нь авч үзсэн, олон улсын чиг хандлагыг аваад үзсэн ч манай мөрдөж байгаа журам болон энэ хэрэгжиж байгаа сургуулиудтайгаа ангиллаар шалгуурыг нь аваад үзэхээр бид нар бол аль аль сургуулиа хангаж байна гэдгээ авч судалгаа хийж үзэхэд 88 сургуулиас их сургууль дээр 10 сургууль л тэнцэхээр харагдаж байгаа. Их, дээд сургууль дээр 12. Энэ ангиллыг авахдаа шууд бол кембрижийн ангилал, карнегийн ангилал гэж авч үзээгүй. Өөрөөр хэлбэл энэ ангилал чинь 2010 оны 26 тоот тушаалаар мөрдөгдөж байсан журам. Энэ ангилал дээр бид нар харьцангуй чанарын баталгаажуулалтыг хангахын тулд, ялангуяа их сургууль дээр бол хөтөлбөрөөс доктор, багш нарын эрдэм шинжилгээний бүтээл дээр илүү голлож ангиллаа хийсэн. Ер нь бол олон улсын чиг хандлага ч гэсэн та бол мэдэж байгаа байх гэж бодож байна. Үндсэн багшийн 60 хувиас дээш хувь нь докторын зэрэгтэй байдаг. Бид нар харьцангуй 50 хувь гэж одоо байгаа хөрсөн дээрээ буулгаж 50 хувиар тавьсан байгаа.

За нөгөө талаасаа энэ урьд нь бол 2010 оны 26 тоот тушаал дээр дээд боловсролын сургуулийн ангилал дээр болохоор үндсэн багшийн 15 хувь нь доктор байгаа байхгүй юу. Тэгээд бид нар өнөөдөр өөрчлөлтөөр бол үндсэн багшийн 10-аас доошгүй гэсэн доктор ангилалтай өгч байгаа. Харьцангуй бид нар түрүүний Мөнхбат гишүүний хэлж байгаагаар өмчийн хэлбэрийг ялгаварлалгүйгээр.. /минут дуусав/

Г.Дамдинням: За түрүүн техникийн саатлаас болоод Гомпилдоогийн Мөнхцэцэг гишүүн нэмэлт 1 минутаа авч чадаагүй. Тэгээд Гомпилдоогийн Мөнхцэцэг гишүүнд 1 нэмэлт нэг минут өгчихье.

Г.Мөнхцэцэг: За баярлалаа. Тэгээд энэ маш том хууль учраас үндсэндээ ярих юм их, олон байгаад байна л даа. Тэгээд бид нар Байнгын хороон дээрээ энийгээ ярьж авч чадахгүй юм бол өөр гаргаад тавьчихаар нэлээн олон юм дагуулах хууль байгаад

байгаа учраас зарим асуудлуудад гүйцэд хариулт авч чадахгүй байгаад байна л даа. Тэгээд нэмэлт минут өгсөнд баярлалаа. Би ер нь товчхон асуултууд бэлдчихсэн байсан. Тэгээд энэ дээр зарим гишүүд маань асуучихсан учраас ер нь энэ хөтөлбөрүүд гэдэг маань үндсэндээ Улаанбаатарын хүрээдэн төв суурин газрын хүрээнд хэрэгжээд явчихдаг. Хөдөө, орон нутгийн гэдэг энэ номууд чинь орхичихдог. Хөдөө, орон нутгийн багш нарын асуудал байгаа, хөдөө, орон нутгийн хүүхдүүдийн асуудал байна гээд ингээд энэ юмнууд чинь орхигдчихдог. Тэгэхээр ер нь бол алслагдсан байдлуудад ямар хуулиар зохицуулалт хийж байгаа юм бэ? Энэ дээр ямар сургалт дээрээс нь орчин нөхцөл сайжруулсах дээр ямар нэмэлт заалтууд байна вэ гэдгийг асууя гэж бодож байсан. Тэгээд энэ асуултуудад хариулт гүйцэд авч чадсангүй.

Хоёрдугаарт ер нь эх хэл гэдэг зүйлийг эх хэл гэдийг чухалчлах даа зайлшгүй шаардлага байгаад байгаа. Энэ хууль нь дээр онцгойлон авч үзэх асуудал байгаад байгаа учраас энэ тал дээр ямар онцгойлж үзэхээр заалт орсон бэ гэдгийг бас асууя гэж бодож байсан юм. Энэ дээр манай сайд онцгойлж анхаарах ёстой байгаад байгаа гэж харж байгаа учраас.

Г.Дамдинням: 2 асуулт орж ирж байна. За энэ хууль бол нийгмийн өөрчлөлтийн шинж чанартай их том хууль учраас гишүүд маань бас нэлээн асуулттай байгаад байна. Ажлын хэсгийн гишүүд маш сайн хариулна шүү. Би хугацааг нь бол чөлөөтэй тавьж өгч байгаа. Тэгээд та хэд бол энэ маш тодорхой, дэлгэрэнгүй, хамаагүй хариулаарай. Хэлэлцэх эсэх өнөөдөр бид нар ярьж байгаа учраас. Түрүүний би сануулаад хэлчихье. Хариулах хүмүүс нь бэлдэж байгаарай. Дэгийн хуультай учраас бид нар бол бас хамаагүй яагаад байж болохгүй байна? Мөнхбат гишүүний асуусан тэр 44.10.1 дүгээр заалттай холбоотой асуулт асуусан. Хоёрдугаарт Учрал гишүүн тэр асуугаад байгаа асуултууд байна. Эд нар дээр асуултууд дээрээ нэмээд хариулаарай ажлын хэсгийнхэн. Энх-Амгалан сайд.

Л.Энх-Амгалан: Мөнхцэцэг гишүүн ээ ер нь ингэж бодож байна. Байнгын хорооны даргаа. Ерөнхийдөө энэ хууль 4 том хууль учраас бол ингээд 2 минутын горимоор асуугаад хариулаад явах их хүндрэлтэй. Тэгэхээр ерөнхийдөө өнөөдөр Байнгын хороогоор хэлэлцэх эсэхийг нь дэмжээд, чуулганаар хэлэлцэх эхийг нь дэмжээд тэгээд мэдээж ажлын хэсэг гарна. Тэрнээс гадна ажлын хэсэг гарахаас өмнө цөмөөрөө бас энэ 8 ажлын хэсгийн тайлан ийм 2 боть ном бэлдэж, энэ хуулийн үндэслэлүүдээ тайлбарласан ажлын хэсгийн тайлангуудыг та бүхэнд хүргүүлсэн байгаа.

Тэгээд ер нь чуулганы нэг өдрийг гаргаад цөмөөрөө вакуумжиж сууж, хуулийнхаа концепцуудыг яг үндэслэл нь яг юу юм бэ, давуу тал нь юу юм, сул тал нь юу юм гэдэг энэ концепцуудыг их сайн тайлбарлаж байж гаргахгүй бол яг иймэрхүү маягийн дэгээр явахад хэн, хэндээ хэцүү. Хариулж байгаа хүндээ ч хэцүү, асууж байгаа хүндээ ч хэцүү байгаад байгаа юм. Тэгэхээр та бас нэг тийм боломж гаргаж өгөөрэй. Энэ хуулийн хэлэлцүүлгүүдийг явахын өмнө яг өргөн барьсан Засгийн газрын байр суурь,

гишүүдтэйгээ хамтарч сууж энэ бас хэлэлцүүлгүүдийг бас тусад нь хэлэлцүүлэг хийе гэж бодож байгаа юм. Бүх гишүүддээ хамруулсан.

Хоёрдугаар асуудал бол. Тэр эх хэлтэй холбоотой асуудал дээр Ням-Очир дарга яг ямархуу зохицуулалтууд орсон байна энийг нэмээд хариулчих? За мөнхбат гишүүний тэр 44.10.1 гэж ярьж байгаа. Энэ бол миний түрүүний тайлбарласан ерөөсөө энэ сургуулийн тоног төхөөрөмжүүд, хөдлөх тоног төхөөрөмжүүд гэж ярьдаг энэ сургуулийн компьютер, лабораториуд энэ сандлуудыг нэгдсэн хөрөнгө оруулалтаар шийдэхээ больё. Ер нь бол энэ нь элэгддэг учраас энэ элэгдлийн зардлуудыг нь тэр тухайн байгууллагынх нь урсгал зардал дээр тавьж өгөөд үүссэн элэгдлийнхээ зардлаар энэ тоног төхөөрөмжүүдийнхээ асуудлыг шийдээд явах нь илүү их зөв асуудал юм байна лээ. Тэгэхгүй бол бид нар сургууль бүхнийг компьютероор, сургууль бүхнийг ширээ, сандлаар хангаж чадахгүй.

Хоёрт бол сургууль өөрөө тэр зардлууд нь ирэхээр ямар чанартай, ширээ, сандал, ямар ч чанартай компьютер, лабораториудыг авах вэ гэдэг тэр санхүүгийнх нь эрх мэдлүүд нь орон нутагт нь, анхан шатанд нь шилжих ийм зайлшгүй шаардлага л байгаа гэж харж байгаа Мөнхбат гишүүн ээ.

Г.Дамдинням: Одоо 3 дугаар микрофон. Ерөнхий боловсролын газрын дарга Ням-Очир.

Т.Ням-Очир: Сургуулийн өмнөх ерөнхий боловсролын хуулийн 7 дугаар зүйл дээр хуулийн төслийн 7 дугаар зүйл дээр сургалтын хэл гэдэг зохицуулалтыг оруулж ирсэн байгаа. Тэгээд цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн сургалт, үйл ажиллагааг Монгол хэлээр зохион байгуулна. Суралцагчийн дийлэнх олонх нь хүн амын өөр хэл бүхий үндэсний цөөнхийн суралцагч байх тохиолдолд цэцэрлэг болон бага ангийн сургалт, үйл ажиллагаа эх хэл дээр зохион байгуулагдаж болохоор зохицуулсан байгаа. Харин дунд, ахлах ангиас бол Монгол хэлээр зохион байгуулахаар дараагийн заалтыг нь оруулж өгсөн байгаа.

Цөөнхийн цөөнхийн тухай асуудал яригдаж байгаа. Тэгэхээр тухайн орон нутагт Монгол хэлээр сургалт явуулдаг, бие даасан сургуулиудыг бол бодлогоор дэмжиж ажиллуулахаар ийм зохицуулалт байгаа. За баярлалаа.

Г.Дамдинням: Түрүүн Энх-Амгалан сайд их ажил хэрэгч санал тавьж байгаа. Ер нь бол Байнгын хорооны даргын хувьд сайдтай бол энэ талаар ярилцаад байгаа. Тэгээд Байнгын хороон дээр чуулган завсарлахаас өмнө ажлын хэсгүүд байгуулагдана. Тэгээд хэлэлцүүлгүүд явна. Ажлын хэсгийн гишүүд энэ хууль, хуулийнхаа чиглэлээр судалгаа шинжилгээ хийнэ. Вакуумжина. Туршлага судлах ёстой бол судална, ярилцана. Тэгээд энэ бүхий л төрлийн арга хэмжээг бол зохион байгуулна. Өнөөдөр хэдүүлээ энэ хэлэлцэх эсэхийг нь хэлэлцэж байгаа ерөнхий агуулгаар нь аваад явъя гэдэг ийм юм ярьж байгаа шүү. За одоо онлайнаар Телунханы Аубакир гишүүн.

Т.Аубакир: За сайн байцгаана уу? Би үг хэлж байна уу. Уучлаарай. Асуулт асууя. Ганц нэг асуулт байгаа юм. Энэ их том хууль орж ирж байна. Талархалтай хандаж байна. Түрүүн Мөнхбат гишүүн бас ярьж байна лээ. Нухацтай авч үзэж, боловсруулж гаргах ёстой хуулийн нэг яах аргагүй мөн. Сая Учрал гишүүн бас хэллээ. Энэ дээр Энх-Амгалан сайдаас тодорхой нэг ганцхан асуулт байна. Энэ 7.2 дээр суралцагчийн дийлэнх олонх хүн амын өөр хэл бүхий үндэсний цөөнхийн суралцагч байх тохиолдолд цэцэрлэг болон бага ангийн сургалт, үйл ажиллагааг эх хэлээр нь зохион байгуулж болно гээд заалт орсон байгаа. Түрүүн бас Ундрэм гишүүн хэлээ. Яг үндэсний цөөнхийн онцлогтой аймаг бол яах аргагүй Баян-Өлгий аймгийн Цэнгэл суманд Тува сургууль бий. Тува хүүхдүүдийг бид нар бас өөрийнхөө төрөлх үндсэн хэлээрээ боловсрол эзэмших эрхийг нь Үндсэн хуулийн дагуу хангаж өгөх ёстой. Мөн казах хүүхдүүдийг бас өөрийнх нь төрөлх хэлээр боловсрол эзэмших эрх нь Үндсэн хуулийн 8.1, 8.2 дээр заагдсан байгаа учраас энэ эрх нь хангагдаж орж ирж байна гэж ойлгож байна. Энэ 9.2, 9.3 энэ заалтууд дээр үндэсний цөөнхөөс суралцагч байх тул цэцэрлэг болон ангийн эх хэл, монгол хэлний сургалтын агуулгыг нэмэх гэдгийг жоохон тодорхой болгоод өгчихмөөр байна Энх-Амгалан сайдаа. Тэр бага ангийн хүүхдүүд буюу 10 жилийн хүүхдүүдэд ордог Казах буюу Тува хэл дээр боловсрол эзэмших эрхтэй байгаа юм бол тэд нарын хэрэглэж байгаа сурах бичгийг наад зах нь боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас зөвшөөрсөн сурах бичиг болгомоор байгаа юм. Одоо бол ер нь үндсэндээ хүлээн зөвшөөрөгдөөгүй энэ тэндээс ирсэн сурах бичгийг ашиглаад байгаа шүү дээ. Тэгэхээр 9.2, 9.3 дээр энэ асуудлыг яг тодруулаад оруулаад өгчихвөл яасан юм бэ? Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас эдгээр хүүхдүүдийн хэрэглэх сурах бичгийг албан ёсны болгоод гэсэн ийм тодорхой санал байна. Энх-Амгалан сайд энийг шууд оруулчих бололцоо бий юу гэсэн ийм асуулт байна.

Г.Дамдинням: Энх-Амгалан сайд хариулъя.

Л.Энх-Амгалан: Манай Аубакир гишүүн, Баделхан гишүүн 2 бол яг энэ хууль дээр үндэсний цөөнхийн хэлний асуудал их чухал, эмзэг асуудал юм шүү. Тийм учраас энэ хууль дээр маш тодорхой зааж өгөөрэй гээд. Бараг үндсэндээ та 2-ын томьёоллоор энэ сургалтын хэл ямар байх вэ, тэр тусмаа үндэсний цөөнхийн түвшинд ямар байх вэ гэдэг асуудал бол бараг яг энэ томьёоллоор орсон. Суралцагчийн дийлэнх олонх нь хүн амын өөр хэл бүхий үндэстний цөөнхийн суралцагч байх тохиолдолд цэцэрлэг болон бага ангийн сургалт, үйл ажиллагааг эх хэлээр нь зохион байгуулна гэж. Тэгэхээр казах хүүхдүүд бол цэцэрлэг дээрээ, бага анги дээр бол казах хэлээрээ, сургуулийн өмнөх боловсрол болон бага боловсролоо авна. Сая харин таны хэлсэн дээшээ дунд анги, ахлах анги руугаа ороход тэр хувилбарт сурах бичиг гээд жаахан ойлгомжгүй юмнууд яваад байгаа юм.

Бид нар энийг ер нь цэгцлээд нэг стандарт руу оруулаад, яг Монгол хэлээр үзэх ёстой хичээлүүдийн стандарт агуулга, сурах бичгүүд бол нэг стандартаар явна. Сонголтын хувилбарт энэ тэр гэдэг ойлголтууд бол байхгүй. Энийг хууль дээрээ таны хэлснээр бас зохицуулаад оруулаад өгчих бололцоо байгаа гэж харж байна аа.

Г.Дамдинням: За Аубакир гишүүн тодруулах уу. Энэ онлайн чинь бас асууж байхгүй бол дараа нь эргэж орж ирээд байх юм. Үгүй гэнэ. Тэгвэл танхимаар Цэрэнжамцын Мөнхцэцэг гишүүн асуулт асууна.

Ц.Мөнхцэцэг: Тэгэхээр энэ боловсролын багц бол нийгэмд маш их хүлээлт үүсгэсэн. Манай шинэ Их Хурлаас бол нийгмийн хамгийн их хүлээж байгаа асуудал учраас энэ бол их чухал асуудлууд байна. За хууль санаачлагчаас 5 асуулт байна.

Нэгдүгээрт. 2020 оны Улсын Их Хурлын сонгуулийн мөрийн хөтөлбөрт Монгол Ардын нам хувийн цэцэрлэг, сургуулийг ашгийн, ашгийн бус гэдгээс хамаарсан бодлого хэрэгжүүлж, ашгийн бус сургалтын байгууллагыг бодлогоор дэмжинэ гэсэн байгаа. Үндсэндээ бид нар нийгэм дэх тэгш бус байдлыг багасгах, энийг хөхүүлэн дэмжиж байгаа ашгийн сургалтын байгууллагуудыг төрөөс тодорхой хэмжээгээр эрх зүйн зохицуулалтыг шинэчлэх ёстой. Гэтэл энэ хуулийн төслийн 18.3-т “боловсролын байгууллага ашгийн төлөө бус эсвэл ашгийн төлөө байж болно” гэж заасан байна. Хэрвээ боловсролын байгууллага ашгийн бус ашгийн байхаар бол хуучин хуультай харьцуулахад ямар шинэ заалтууд орж байгаа вэ? Татварын болон бусад заалтууд дээр мөн маш өндөр төлбөртэй хувийн сургуулиудын төлбөрийн зарцуулалт болон санхүүжилт бол маш ил тод бус байдаг. Эцэг эхчүүд болон хүүхэд, суралцагч нарт бол нээлттэй бус байдаг. Тийм учраас хэрвээ ашгийн байгууллагыг зөвшөөрч байгаа бол шинэчлэлийн ямар заалтууд байгаа вэ?

Хоёрдугаарт. Хувийн хэвшлийн маш олон сургууль 10 саяас дээш төлбөртэй. Дээд тал нь 60 сая хүртэл байгаад байна. Тэгэхээр энэ олон өндөр төлбөртэй хувийн сургуулиудад төрөөс олгож байгаа хувьсах зардлыг яаж олох вэ? Хүн амын маань 90 хувь нь сурч байгаа улсын сургуулиудаа дэмжих шаардлага бол бид нарт байна. Тэгвэл Боловсролын тухай шинэ хуульд төрийн хэвшлийн сургуулиудыг дэмжих тал дээр ямар заалтууд орсон байгаа вэ?

Гуравдугаар асуулт. Ер нь цар тахлын 2 жил бол бид нарт маш их асуудлуудыг гаргалаа. Үүний 1 бол танхимын сургалтуудаа зогсоож бид нар зайны болон цахим сургалтад шилжсэн энэ хугацаанд орлого багатай, мөн алслагдсан бүс нутгийн хүүхдүүд интернэт, телевиз гэдэг юм уу, за нөхөн үзэх тоног, төхөөрөмжүүд./минут дуусав/

Г.Дамдинням: Мөнхцэцэг гишүүнд 1 минут.

Ц.Мөнхцэцэг: Зайны болон цахим сургалтууд маань тэгш бус байдлыг дэмжиж байгаа нэг ийм хэлбэр болчихсон. Тэгвэл Боловсролын тухай шинэ хуульд энэ тэгш бус байдлыг бий болгоод байгаа энэ асуудлыг яаж хязгаарлах вэ? Орлого багатай болон эмзэг бүлгийн хүүхдүүдэд сургалтын тэгш хүртээмжийг бий болгох тал дээр ямар заалтууд орсон бэ? Энэ төслийн 8.3 дээр “танхимын бус сургалтад зайны болон цахим сургалтыг дэмжинэ.” гэж оруулсан. Тэгвэл 21 дүгээр зүйл “Боловсролын байгууллага байгуулах тухай” энэ заалт дээрээ заавал танхимын сургалт явуулах агуулгаар нь боловсролын байгууллагыг хүлээн зөвшөөрчихжээ. Өөрөөр хэлбэл цахим болон зайны

сургалтыг явуулах онлайн сургалтууд. Дэлхийн маш олон улс оронд онлайн сургалтууд байдаг. Тэгвэл энэ сургалтын байгууллагыг дэмжих тал дээр цахим сургалтын үйл ажиллагаатай зөрчилдөөд байгаа юм биш үү? Заавал танхимын сургалт явуулдаг байгууллагыг хүлээн зөвшөөрч заасан байна.

Тавдугаар асуулт. Хилийн чанадад байгаа Монгол хүүхдүүд эх хэлээрээ сурах тухай асуудал дээр ямар шинэ гарц.../минут дуусав/

Г.Дамдинням: За хэн хариулах вэ? Энх-Амгалан сайд.

Л.Энх-Амгалан: Бид нар үндсэн хуулиараа өмчийн эрх бол хүн бүхэнд л ингээд өмчийн эрхээ хамгаалуулах ийм эрхтэй. Ийм Үндсэн хуультай улс орон. Ер нь энэ боловсролын салбарт хувийн хэвшлийнхний оруулсан хувь нэмэр бол маш их байна. Өнөөдөр сургуулийн өмнөх боловсрол гэхэд 1454 цэцэрлэг байхад төрийнхөн нь 948, хувийнх нь 506 зургаан цэцэрлэг байгаа. Нийт 860, 870-аад сургууль байхад бол төрийн өмчийнх нь 670-аад, хувийн өмчийнх нь болбол 160, 170 бага дунд боловсролын сургуулиуд байж байгаа. Их, дээд сургуулиуд дээр 88 их, дээд сургуулиуд байхад үндсэндээ бараг 60 гаран нь хувийн өмчийн их, дээд сургууль байх жишээтэй.

Тийм учраас өнөөдөр энэ боловсролын салбарт байгаа их сайн жишиг тогтоож байгаа хувийн сургууль, цэцэрлэг, их дээд сургуулиудыг бид нар дэмжих ёстой. Тэрнээс биш төрийнхийг нь илүү их дэмжээд, хувийнхыг нь бага дэмжинэ гэдэг ийм ойлголт байж болохгүй. Тэгэхээр энэ хуулийн нэг гол зүйл бол өмнө нь хувийн сургуулиуд нь яг статус нэг их тодорхойгүй байсан юм. Мөнхцэцэг гишүүн ээ. Хувийн сургуулиуд, их, дээд сургуулиуд, цэцэрлэг ч адилхан. Яг ашгийн төлөө байгаа мөртөө ашигтай ажиллаж байгаа мөртөө тэр нь төрийн бус байгууллагуудаар бүртгүүлчихдэг учраас татвар дээр татвар төлдөггүй. Тэгсэн мөртөө өөрөө тодорхой дивидент ашгаа өөр хэлбэрээр хувааж авдаг. Яг ингээд өмчөө захиран зарцуулах тэр эрх нь бас яг тэр компанийн зохион байгуулалтынхаа хуулиар тэр нь бас олгогдоогүй гэх мэтчилэнгээр ойлгомжгүй зүйлүүд их байсан. Одоо манай хувийн цэцэрлэг, сургуулиуд та нар яг үнэхээр бид нар хувийн өмчтэй сургууль юм чинь компанийн хуулиар зохицуулж болно гэдэг. Энэ эрх зүйн өөрчлөлтийг хийгээд байх юм бол бид нар компанийнхаа хуулиар л бүх зүйлээ зохицуулаад явъя л гэж байгаа шүү дээ.

Г.Дамдинням: Энх-Амгалан сайд нэмээд хариулчих.

Л.Энх-Амгалан: Төрийн болон хувийн өмчит сургуулиудын статусын асуудлуудаараа бас ийм нэмэлт тайлбар өгчихье гэж бодож байна.

Хоёрдугаарт болбол манай Мөнхцэцэг гишүүн хамгийн чухал асуудлыг хөндөж ярьж байна. Ер нь бол КОВИД-ын үед бид нарын өмнө нь тулсан хамгийн том сорилт бол яаж энэ боловсрол хүртээмжтэй, чанартайгаар танхимын бус аргаар хүргэх вэ л гэдэг ийм том сорилт байсан. Энийг манай боловсролын салбар бол маш амжилттай давж чадсан гэж ойлгож байгаа юм. Магадгүй нөгөө эрсдэл бол боломж гэдэгтэй адилхнаар цаашдаа цахим шилжилт хийх энэ боломжийг КОВИД олгосон. Тэгэхээр бид

нар эрх зүйн энэ хуулийнхаа өөрчлөлт дээр ер нь цаашдаа 100 хувь цэцэрлэг, бага дунд сургууль дээр 100 хувь танхимын сургалт байхгүй. Хосолмол сургалтууд бий болно. Уламжлалт бус буюу танхимын бус алсын зайн теле хичээлүүд бий болно. Сая та бүхэн харсан байх. Өчигдөр Мэдлээ.mn гэж Монгол Улсын анхны цахим сургуулийн платформ бий болж байгаа. 1-12 дугаар ангийн 17 мянган хичээлийг манай 40 мянган багш нар энэ дунд өөрсдийнхөө мэдлэг чадвараар теле хичээл, цахим хичээл болох анхны цахим сургуулийн платформын үндэс тавигдаж байна.

Өнөөдөр Баян-Өлгийд сурч байгаа хүүхэд Дорнод аймагт сурч байгаа хүүхэд 1 дүгээр сургуулийн математикийн багш эсвэл 11 дүгээр сургуулийн биологийн багш эсвэл 23 дугаар сургуулийн англи хэлний багшаар заалгах энэ эрх нь байгаа. Тийм учраас бол хаана амьдарч, хаана сурч байгаагаас үл шалтгаалаад ахлах сургуулиудын хувьд сонгон хичээлүүдээ бол тодорхой кредитүүдээ багшаа сонгож, хөтөлбөрөө сонгож сонгон кредитдээ тооцуулах боломжуудыг л бид нар энэ хуулиараа нээж өгч байгаа байхгүй юу. Тэгэхээр бид нарт энэ боловсролын цахим шилжилт бол боловсролын салбарт үүссэн байсан хоцрогдлыг нөхөх маш том боломжийг олгож байна. Таны түрүүний хэлдэг эх, эцгийнх нь орлого багатай эсвэл алслагдсан сум, сууринд амьдарч байгаа хүүхдүүд бол яг энэ КОВИД-ын үед бол үндсэндээ маш том хоцрогдолд орсон. Одоо улсын хэмжээнд 180 мянган хүүхэд цахилгаангүй, интернэтгүй, гар утасгүй, телевизгүйгээс болоод 180 мянган хүүхэд бодитой хоцрогдолд орчихоод байна. За сая Засгийн газар дээр манай яам хоцрогдлыг арилгах үндэсний хөтөлбөр боловсруулж 3 жилийн үндэсний хөтөлбөрийг боловсруулж батлуулж байна. Энэ 3 жилийн хугацаанд боловсролынхоо хоцрогдлыг илүү цахим хэлбэрээрээ нөхөх ийм л боломж бид нарт олдож байгаа гэж харж байгаа юм. Ер нь тэгээд цаашдаа бүх сургуулиуд, бүх сургуулийнхаа сургалтыг бас цахим болгож болохгүй. Сургуулийн өмнөх боловсрол, бага, дунд, ахлах боловсрол дээр заавал танхимаар үзэх хичээл гэж байна. Нийт хүүхдүүд авах ёстой мэдлийнхээ 60-70 хувийг танхимаар сууж байж авдаг ийм судалгаа, хэрэгцээ, шаардлага байгаа учраас танхимын болон танхимын бус гэдэг хосолмол аргууд нь явах болов уу гэж бодож байна.

Цаашдаа их, дээд сургуулиудын хувьд магадгүй энэтхэгийн нээлттэй их, дээд сургуулиудтай адилхнаар 100 хувь цахим сургуулиудаа үүсгэхийг бид нар үгүйсгэхгүй байгаа.

Г.Дамдинням: Хассуурийн Ганхуяг гишүүн асуулт асууна.

Х.Ганхуяг: За хуультай яг танилцаж амжаагүй байна. Тэгэхдээ өнөөдөр бас танаас хэдэн асуух асуултууд байна.

Нэгдүгээрт. Мэргэжлийн боловсролын асуудлыг яагаад энэ боловсролын хуульдаа оруулаагүй юм бэ? Энэний шийдэл нь гаргах цаг нь болсон юм биш үү? Тэгээд яг гол бодлогын юм нь болохоор Нийгмийн бодлогын байнгын хороогоор явчихдаг. Энэ чинь Боловсролын яам гэдэг чинь бол ер нь бол үндсэндээ Монгол Улс

хүний нөөцийн яам л гэсэн үг шүү дээ. Тэгээд ерөнхий боловсролд нь яах юм? Бид нар ерөнхий боловсрол төгсөж байгаа улсуудыг бүгдийг нь дээд сургууль төгссөн гэсэн бодлогоор яам ажиллах юм уу, аль эсвэл яг яаж ажиллана гэсэн үг вэ. Энэ нэг бодлогын алдаа байх шиг байгаад байна. Энэ дээр яаралтай шийдэл гаргаж өгөөч гээд хүсэх гэсэн юм.

Хоёрдугаар асуудал. Та энэ ашгийн болон ашгийн бус байгууллагуудыг хэн тодорхойлох талаар саналаа өгөхгүй юу даа. Энэ олон улсын практикт татварын газар нь аудит хийгээд, тэгээд тэр дээрээ ашгийн байна уу, ашгийн бус байна уу гэж тодорхойлоод явчихдаг. Манайх чинь болохоор ашгийн бус гэсэн байдалтайгаар л төрийн бус байгууллага байгуулаад л, тэгээд л тэр ашгаар нь машин аваад, байр аваад л явчихдаг шүү дээ. Энэ бол хэнд ч нууц биш. Хамгийн үнэтэй газар авч байгаад байшин бариад явчихдаг.

Гуравдугаар асуудал. Нэрээ ашгийн болон ашгийн бус гэж хувааж байгаа бол энэ хүүхдүүдэд олгодог хувьсгал зардлыг ашгийн байгууллагуудад олгох эсэх тал дээр энэ хуульд яаж туссан байгаа вэ?

Дөрөв дэх асуудал болохоор энэ цахим сургуультай холбогдуулаад бид нар Баянгол дүүрэг дээр нэлээн юмнууд хийсэн л дээ. Тэгээд яах вэ бас багш нар маань өөрсдөө яг тэр цахим шилжилттэй холбогдуулан нэлээн хоцрогдолтой байна лээ. Тэгээд энэ тал дээр багш нараа бэлтгэх тал дээр анхаарах ажил хийгдэж байгаа юу вэ гэдэг асуулт асуух гэсэн юм.

Тавдугаар асуудал болохоор би танд өмнө нь хэлж байсан. Би таныг энэ цахим шилжилттэй холбоотойгоор Баянгол дүүргүүд дээр хэрэгжүүлж байгаа цахим боловсролтой холбоотой танд ганц бичиг өгсөн. Одоо үндсэндээ 3 сар болж байна. Надад хариу өгөхгүй байна л даа.

Г.Дамдинням: Энх-Амгалан сайд хариулъя.

Л.Энх-Амгалан: Мэргэжлийн боловсрол бол боловсролын тогтолцооны нэг хэсэг байх ёстой. Энэ нь 2012 онд Алтанхуягийн Засгийн газрын үед л ийм ойлгомжгүй мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, коллежуудыг Хөдөлмөрийн яамны харьяанд аваачсанаар маш том гажуудал гарсан. Энэнийхээ горьг ч гэсэн бид нар амсаж байх шиг байна. Тэгэхээр өнөөдөр Засгийн газрын хуралдаанаар мэргэжлийн боловсролын тухай хууль хэлэлцэгдэж Улсын Их Хуралд өргөн барихаар болж байгаа. Тийм учраас Боловсролын ерөнхий хууль ороод ирчихсэн энэ үед болбол энэ мэргэжлийн боловсролынхоо хуулийг хамтад нь хэлэлцээд магадгүй одоогийн үйлчилж байгаа хуулиар бол Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд өргөн барьж байгаа. За энэ хуулийг хэлэлцэх нь Нийгмийн бодлогын байнгын хороо болчихоод байгаа. Тэгэхээр бид нар Их Хурал дээр нэгэнт Боловсролын ерөнхий хууль орж ирээд Боловсролынхоо ерөнхий хууль дээр бид нар мэргэжлийн боловсрол, техникийн боловсрол, боловсролын тогтолцооны нэг хэсэг байна гээд заагаад өгчихсөн учраас бол энэ мэргэжлийн

боловсролынхоо хуулийг Их Хурлын даргын захирамжаар хамтарсан Байнгын хороо гаргаж энэ өнөөдрийн алдаа завхралуудыг бид нар засах ёстой гэж бодож байгаа юм.

Буруу юмыг яагаад ч зөв болгох гээд боддоггүй. Тийм учраас бид нар энэ 12 жилийнхээ тогтолцоотой уялдуулж мэргэжлийн боловсролынхоо тогтолцоо нэгдүгээрт.

Хоёрдугаарт бол тэр мэргэжлийн үндэсний шаталсан бүтэцтэйгээ уялдуулж, мэргэжлийн болон техникийн боловсролынхоо бүтэц тогтолцоог өөрчлөх, зах зээлийнх нь эрэлт хэрэгцээнд нийлүүлсэн өрсөлдөхүйц чадвартай боловсон хүчинд бүрдэх энэ тогтолцоогоо бид нар сайжруулж явах ёстой юм байна гэж бодож байгаа юм. Одоо үндсэндээ МСҮТ, коллежууд чинь бол их ойлгомжгүй болчихсон шүү дээ. Зарим нь Боловсролын яам дээр, зарим нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам дээр. Коллеж гээд байж байна. Косен гээд байж байна. Энэ мэтчилэнгээр мэргэжлийн боловсрол, техникийн боловсролынхоо тогтолцоог бид нар яг энэ Боловсролын ерөнхий хууль хэлэлцэж байгаа үетэйгээ нэгтгэн бүгдийг нь засаж залруулж зөв горимд нь оруулах ийм шаардлага өнөөдөр байна. Тантай санал нэг байна.

Хоёрдугаар асуудал бол.../минут дуусав/

Г.Дамдинням: Энх-Амгалан сайдад микрофон нэмээд өгөөрэй.

Л.Энх-Амгалан: За ер нь тэгээд ашгийн төлөө байгууллага бол тэгээд үндсэндээ компанийн хуулиар зохион байгуулагдах учраас компани бол тэгээд татварт бүртгэгдэнэ. Тэгээд татвар төлөгч болоод явах ёстой. Бид нар ер нь ингэж зохицуулалт хийх ёстой. Тэгэхгүй бол үндсэндээ энэ сургалтын байгууллага гэдэг чинь өөрөө статус нэг их тодорхой бус олон жил явсан учраас энэ татварын хийдлүүд их байдаг юм байна лээ. Хөрөнгө, мөнгөтэй холбоотой асуудлууд ч байгаа. За тэгээд энэ асуудлуудыг нэг нэг талд нь, нэг нь бол нийтийн эрх зүйн хуулиараа зохицуулагдаад явагдана, нөгөөдөх нь бол компанийн хуулиар зохицуулагдаад явах энэ боломжууд нь байгаа.

Ер нь цаашдаа бид нар үнэхээр ашгийн төлөө байгууллага гээд өөрийгөө бүртгээд явж байгаа сургуулиуд дээр хувьсах зардал өгөөд сууж байна гэдэг энэ бол дэмийн байх. Энэ бол буруу зарчим гэж ойлгож байгаа. Ашигтай л ажиллах гэж байна шүү дээ. Тийм учраас ахиад тэр дээр нь нэмээд хувьсах зардал өгөөд байхад шаардлага байхгүй л гэж бодож байгаа юм.

Гуравдугаар асуудал бол энэ цахим шилжилтийн асуудал байна. За энэ дээр болбол би түрүүн Мөнхцэцэг гишүүний асуултад хариулсан. Ер нь бол манай багш нарын мэдээлэл технологийн чадвар, мэдээлэл технологийн хэрэглээ гэдэг бол яг өнөөдөр бодитой хэрэгцээ шаардлага дээр үндэслэхдээ бол нэлээн хоцрогдолтой явж байгаа. Улаанбаатар хотын захын дүүргийн сургуулиуд, аймгийн төвийн сургуулиуд, сумын төвийн сургуулиуд дээр яг ийм орчин нөхцөлүүд байна. Яагаад гэвэл өнөөдөр шилэн кабелийн холболтын хурдны хэмжээ, сургуулиуд дээр байгаа WI-FI орчин, багш нарын хэрэглэж байгаа сургалтдаа хэрэглэж байгаа компьютеруудын хурдын асуудлуудаас авхуулаад, хүрэлцээ хангамжийн асуудлаас авхуулаад маш их тийм IT-

ийн том digital divide гэж ярьдаг, тийм үү? Энэ хоцрогдлууд үүсчихсэн байна. Өнөөдөр 24 хүүхдийн дунд ганцхан компьютер л оногддог л ийм л улс орон болчихоод сууж байна шүү дээ. Тэгэхээр энийг зайлшгүйгээр энэ цахим шилжилтийн үед бол цахим шилжилтээ зөв богино хугацаанд шийдэж, үнэхээр тэр боловсролын чанар, хүртээмжийн чанарын ялгааг арилгая гэх юм бол энэ цахим дэд бүтцийнхээ асуудлуудыг зайлшгүй шийдвэрлэх ийм нөхцөлүүд бид нарын өмнө тулгамдаж байна. Энэ бол бид нарын өмнө тулгамдаж байгаа маш том сорилт юм. За Ганхуяг гишүүний бичигтэй холбоотой асуулт дээр хэн хариулт өгөх вэ? Төрийн нарийн бичгийн дарга хариулт өгөх үү? Яагаад 3 сар Улсын Их Хурлын гишүүний ... та одоо хариулт өгөөрэй. Наадхаа. Тодруулчихаад.

Г.Дамдинням: Энх-Амгалан сайд болчихсон уу?

Л.Энх-Амгалан: Ер нь 3 сар болсон бичиг байхгүй дээ манай юман дээр. Хэрэв үнэхээр 3 сар үнэхээр тэр бичиг байгаа бол тэр хүнтэй хариуцлага тооц.

Г.Дамдинням: Хоёр номерын микрофон. Төрийн нарийн бичгийн дарга Батбаатар. Их Хурлын гишүүний асуусан асуултад хариулах тухай асуудал.

Д.Батбаатар: Гишүүний саяны албан тоотыг би одоо яг тодруулж байна. Тодруулчихаад эргээд хариу өгье танд.

Г.Дамдинням: Ер нь энэ яамны нөхдүүдэд бас анхааруулахад Их Хурлын гишүүд, Байнгын хорооны гишүүдээс заримдаа ийм гомдол ирээд байгаа шүү. Хуультай. Хуулийн дагуу асуулт асуухаар хариу нь ирдэггүй. Тэгээд сая Байнгын хорооны хуралдаан дээр асуулт асуухад хүртэл ингээд тойрох маягаар яваад сайдаас нь өөр тодорхой хариулт өгдөг хүнгүй л болчихоод байна л даа. Ганхуяг гишүүн тодруулах юм уу?

Х.Ганхуяг: Үндсэндээ манайх чинь яг хувийн сургууль гэх юм бол бараг нийт сургуулийнхаа 10 гаруй хувьтай тэнцэхүйц хэмжээний хувийн сургууль байгуулагдсан юм байна лээ л дээ. Тэгээд Улаанбаатар хотод бол бас хувийн сургуулиуд руу хүүхдүүдээ зөөх асуудал бол үндсэндээ түгжрэлийн нэг шалтгаан болчихоод байгаа л даа. Тэгээд энэ дээр ер нь ямаршуу байдлаар энэ дээр тийм туссан зүйл заалт байгаа юу? Асуулт нь юу вэ гэхээр нэг бол хүүхдүүдээ тэр сургууль руугаа хувийн сургууль юм чинь автобусаар нь зөөх шаардлага тавих ч юм уу, аль эсвэл харьяа дүүрэг, хорооноосоо хүүхдийг авах ч байдаг юм уу гэх мэтчилэн энэ асуудлыг хэрхэн яаж шийдэх гэж байгаа вэ? Бид нар чинь түгжрэл гээд Улаанбаатар хотын түгжрэлийг шийднэ гээд асар их хэмжээтэй төсөв бариад байдаг. Гэтэл энэ чинь боловсролынхоо асуудал дээр гол шалтгаануудын нэг нь яваад байгаа байхгүй юу. Тэгээд энэ тал дээр ер нь ямар зохицуулалт орж байгаа вэ?

Г.Дамдинням: Энх-Амгалан сайд.

Л.Энх-Амгалан: Энэ их хэцүү асуудал. Тэр тусмаа Улаанбаатар хотод. Тэгээд хувийн үнэтэй сургуулиуд дээр хамран сургалтдаа хүүхдүүдээ ав гэж хэлэхэд бас их хэцүү. Жишээ нь. Орчлон дээр гэдэг юм уу, Шинэ Монгол дээр чинь яг тэр орчин тойрныхоо хүүхдүүдийг аваарай гэхээр тэр хүүхдүүдийнх нь хэд нь өнөөдөр тэр 10 сая, 15 сая төгрөгийн төлбөрийг төлж суралцах вэ гэдэг их тийм хэцүү асуудал.

Гэхдээ бид нарын барьж байгаа бодлого бол хүүхдийг аль болохоор хамран сургах, амьдарч байгаа дүүрэг, хороонд нь ойрхон сургах боломжуудыг бид нар тэгш хамран сургах боломж, хүртээмжийг дээшлүүлэх чиглэл бол бид нар бодлого барих ёстой гэж ойлгож байгаа юм. За ер нь бол 1 километр дотор л хүүхэд явах ёстой юм байна лээ шүү дээ. 1 километрээс илүү гарах ёсгүй юм билээ. Тэр тусмаа сургуулийн өмнөх боловсрол, бага боловсролын хүрээнд бол хийсэн судалгаагаар ийм юм байна лээ. Тэгэхээр бид нар энэ цэцэрлэг, бага сургуулийн цогцолбор гэж түрүүн Баатарбилэг сайдын үед гаргасан концепц гэж би түрүүн онцолж хэлсэн. Тэгэхээр энэ гэр хорооллын дунд том 12 жилийн сургууль барина гэдэг бол маш их том газар шаарддаг, маш их хөрөнгө оруулалт шаардагддаг ийм зүйл байгаа. Энийг бид нар цэцэрлэг, сургуулийнх нь цогцолбор хэлбэрээр шийдэх юм бол 2 айлын, 4 айлын газар аваад шийдчих. Тэр нь дунд сургуулийнхаа харьяа байгаад дунд, ахлах сургууль руугаа шилжих. Томоор барьж байгаа олон мянган айлуудын хорооллуудыг барьж байгаа энэ хорооллууд дээр төр газар өгөхдөө 1 давхрынх нь асуудлуудыг 1 давхрыг бол заавал ч үгүй цэцэрлэг, бага сургуулийн зориулалтуудаар авч үлддэг ийм зохицуулалтуудыг хийх ёстой гэж хоттой ярьж эхний ажлуудаа хийх гэж байна.

Тэгэхээр бид нар цэцэрлэг, бага сургуулийнхаа стандартыг жаахан уян хатан болох ёстой юм байна лээ. Тэр тусмаа байгууллагуудын цэцэрлэг гэдэг асуудлууд бас бодитой гарч ирж байгаа учраас яам ч гэсэн бас энэ бодлогоо жаахан уяатай болгоё. Ер нь ийм бодлого руугаа харъя. Ер нь хотын түгжрэлийн бараг 40 хувь нь өглөө хүүхдээ хүргэх, орой хүүхдээ авах цэцэрлэг сургуулийн хувьд ийм.../минут дуусав/

Г.Дамдинням: Энх-Амгалан сайд нэмээд хариулчих.

Л.Энх-Амгалан: Тэгэхээр бид нар энэ дээр энэ жил энэ намраас Улаанбаатар хоттой хамтраад нэг хамгийн их ачаалал үүсгэж байгаа дүүргүүд дээр 60 цэцэрлэг дээр нэг ээлжийн багш ажиллуулах асуудлыг сая Засгийн газраа оруулж бас шийдэж байгаа. Энэ бол өглөө эрт цэцэрлэг эхэлнэ. Хүүхдүүд нь бас арай 2, 3 цагаар орой сунгаад авчихдаг. Тэгээд эцэг, эхчүүд нь өглөө ажилд ирэхээсээ өмнө хүүхдээ цэцэрлэгт өгчихдөг, орой ажил тарсныхаа дараа сунгасан цагаар ажиллаж байгаа ээлжийн багштай ажиллаж байгаа хүүхдүүдээ орой ирээд авчих юм бол магадгүй энэ Улаанбаатар хотын энэ замын ачаалалд бол тодорхой, богино хугацаанд үр дүн өгөх ийм шийдлүүд нь байх юм байна гэж харж байгаа. Энэ намар энэ намрын хичээлийн шинэ жилээс ийм зүйлүүдийг эхэлье гэж бодож байгаа.

Ерөөсөө Засгийн газрын мөрийн хөтөлбөр дээр чинь 270 цэцэрлэг, 200 сургууль барих ийм л гол зорилт тусчихсан байгаа юм. Тэгэхээр бид нарын нөгөө нэг газар зүйн

мэдээллийн систем School map гэж яриад байгаа асуудлуудыг л энэ жилээс хөрөнгө оруулалт дээрээ тэр зарчмаа барья. Өнөөдөр Баянгол дүүргийн яг аль хороонд нь хамгийн их ачаалал, хамгийн их цэцэрлэгийн өмнөх насны хүүхдүүдтэй бага сургуульд орох хүүхдүүд байна тэнд нь л тэр хорооны гэр хорооллынхон дунд нь 2 айл 4 айлын газруудыг худалдан авалтууд хийгээд тэгээд цэцэрлэг, бага сургуулийнх нь цогцолбор маягаар шийдэж чадах юм бол маш богино хугацаанд цэцэрлэгийн хамрагдалтын асуудлууд, бага сургуулийн сургуульд орох хүүхдүүдийн сургуульдаа орох боломжуудыг хангах шийдэл нь ерөөсөө энэ л юм байна лээ.

Г.Дамдинням: Гишүүд бол бас энэ төр, хувийн хэвшлийн сургуулиудын ялгаа, хөтөлбөрийн үнэлгээ, тэгээд түгжрэлтэй холбоотой асуудал, хичээлийн хоцрогдол, олон улсын стандартад нийцэх тухай асуудал, магадлан тэгээд ер нь бол боловсролын салбартай холбоотой томоохон өөрчлөлтүүдийн концепцын талаар нэлээдгүй их асуултуудыг асуулаа. Асуултууд дараа дараачийн хэлэлцүүлгүүд дээр тодорхой хариулж байхыг энэ ажлын хэсгийн гишүүдэд дахин сануулъя.

Ингээд Боловсролын ерөнхий хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн үзэл баримтлалыг танилцуулсан хууль санаачлагчийн илтгэлтэй холбоотой асуулт асууж дууслаа.

Хуулийн төсөл санаачлагчийн илтгэлтэй холбогдуулан үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү. Энх-Амгалан гишүүнээр тасалъя. Цахимаар байна уу. За Энх-Амгалан гишүүн. За Баатарбилэг гишүүн. 3 минут.

Ё.Баатарбилэг: Төслийг хэлэлцэхийг дэмжиж байгаа. Тэгэхээр Боловсролын ерөнхий багц хуулиудын төслийг хэлэлцэхийг дэмжиж байгаа. Өнөөдөр хэлэлцэх эсэх асуудал явагдаж байна. Ер нь бол яах вэ? Хуулийн төслүүд дээр нэлээд цаг үеэ олсон, нааштай, тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх олон заалтууд орж ирсэн байна. Нөгөө талаараа түрүүн гишүүд бас асуугаад энэ цахим хуралдааны дэгээр бас тодорхой хариултууд авч чадахгүй байгаа нэлээд олон асуудлууд байна. Зарчмын бас асуудлууд байна. Тэгэхээр эд нарыгаа бол хэлэлцэх эсэхийн дараа ажлын хэсгээ байгуулаад ингээд явах нь, тэр дээрээ нэлээд сайн яриад явах байх. Би нэг юман дээр Боловсролын сайдтай санал нийлэхгүй байна.

Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүдийнхээ асуудлыг нэг тийш нь болгох асуудлыг ингэж 2 Байнгын хорооны асуудал болгож явах ёсгүй уг нь. Энэ чинь мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн мэргэжлийн боловсролын сургалт бол боловсролын асуудал, цэвэр боловсролын асуудал. Энэ хөдөлмөрийн байгууллага биш боловсролын байгууллага. Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүд бол. Яахаараа боловсролын байгууллагыг Нийгмийн бодлогын байнгын хорооны хурлаар асуудал Нийгмийн хамгааллын яамнаас тавьж оруулж ирдэг юм. Энэ дээр бол Боловсролын байнгын хорооны дарга ч гэсэн байр сууриа илэрхийлэх хэрэгтэй. Энэ бол боловсролын байгууллага болохоос хөдөлмөрийн байгууллага биш. Хөдөлмөрийн хүн бэлдэж байгаа гэдэг тайлбар тавьж байгаа юм. Тэгвэл дээд боловсролынхоо

байгууллагыг ч гэсэн тэгвэл Нийгмийн хамгааллын яаманд өгөх хэрэгтэй. Хөдөлмөрийн хүн, мэргэжилтэй ажилтан бэлдэж байгаа гэж ярьдаг байхгүй юу. Тэгэхээр энийгээ нэг мөсөн болгоод, эсвэл энэ дотроос энэ мэргэжлийн боловсрол гэсэн бүх үгнүүдийг гаргах хэрэгтэй. Яахаараа тэгвэл Хөдөлмөрийн яам хариуцаж байгаа Нийгмийн бодлогын байнгын хороогоор хэлэлцдэг тэдний байгууллагын асуудлыг манайх энэ манай харьяаны байгууллагын ерөнхий хуульд орж ирж ирэх ёстой юм. Тэгэхээр энийг бол уг нь 2 сайд яриад засаг дээрээ шийдлээ гаргаад нэгмөсөн мэргэжлийн боловсролынхоо хуулийг энэ хуультайгаа нийцүүлээд Монголын боловсролын тогтолцоог бүрэн гүйцэд болгох асуудлыг гаргаж тавих ёстой гэж үзэж байгаа юм.

Тэгэхээр энэ дээр цаашид 2 Байнгын хорооны дарга ч гэсэн 2 сайд ч гэсэн засаг дээрээ ч, Их Хурал дээрээ ч гэсэн шийдэл гаргаад явахгүй бол энэнээс болж маш олон хүүхэд залуучууд хохирч байгаа шүү. Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүд бол үндсэндээ нэлээд хүнд байдалд орсон байгаа гэдгийг хэлье. Мэдээж энэ хуулийн төсөл дотор байгаа зүйл, заалтуудтай холбоотой зарчмын зөрүүтэй маш олон асуудлууд байгаа. Энийг бол түрүүн хэлсэн. Сайд хэлсэн. Байнгын хорооны гишүүдтэйгээ эхний ээлжид нэлээд дэлгэрэнгүй хуулийнхаа заалтуудыг ч та бүхэн танилцуул, тайлбарла. Бид нар ч гэсэн бас тодорхойгүй байгаа зарчмын зөрүүтэй асуудлууд дээрээ тодорхой тайлбарууд авч ойлголттой болохгүй бол ойлголтын зөрүүнүүд байна. Нөгөө талаараа ойлголтын зөрүү биш ч гэсэн зарчмын өөр байр сууриуд байгаа учраас ингэж асуудлыг нэлээн сайн нэгтгэж явах хэрэгтэй байна шүү гэдгийг хэлье.

Г.Дамдинням: За Баатарбилэг гишүүн бас их чухал санал хэлж байна. Тэгээд ер нь Байнгын хорооны даргын хувьд даргын дэргэдэх зөвлөл болон Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн яам, Боловсрол, шинжлэх ухааны яамтай бол уулзаад ярилцаад зарчмын шийдэл ер нь бол гарч байгаа. Тийм биз Энх-Амгалан сайдаа. Тэгээд засаг дээрээ бас ярилцсан юм байна лээ. Ер нь бол шийдчихсэн. Тэгээд ойрын үед бол бид нар энэ мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг өргөн барь гэдэг асуудлыг Их Хурлын даргаас бол явуулж байгаа. Тэгээд өнөөдөр өргөн барьж байгаа гэж мэдээлэл байна. Тэгээд ороод ирэхээр нь ер нь боловсруулах хүнийг бэлдэх асуудал бол энэ боловсролын яамны асуудал байхгүй юу. Тэгэхээр яг тантай санал нэг байгаа. Зарчмын хувьд энийг шийдээд явна. Одоо ингээд цахимаар Ц.Мөнхцэцэг гишүүн үг хэлнэ.

Ц.Мөнхцэцэг: Байна уу?

Г.Дамдинням: Сонсогдож байна. Яриарай.

Ц.Мөнхцэцэг: Сүлжээ тасраад байна. Жоохон байж байгаад тахимаар орж үг хэлье.

Г.Дамдинням: Жамъянгийн Мөнхбат гишүүн.

Ж.Мөнхбат: Хэлэлцэх эсэхийг дэмжиж байгаа. Тэгээд яах вэ. Энэ цар тахлын дэгээр 2 минутад, 3 минутад асуугаад ийм зузаан хуулийг бол 2 хоногийн дотор 5

хоногийн дотор уншаад явна гэж байхгүй. Тэгэхээр энэ намрын чуулган дээр энэ асуудлыг ярьж батлах болтол цаг хугацаа байна хэлэлцүүлгүүдээ сайн зохион байгуулаарай. Энх-Амгалан сайд аа, Ганбаяр сайд аа. Манай Боловсролын яамныхан. Ноднин жилийн хэлэлцүүлгүүд бол их үр дүнтэй болсон. Олон саналууд ирсэн. Тэр саналуудыг тусгаж, бас яг тэр боловсролын салбарт, бүх салбарт нь сургуулийн өмнөх, дээд, дунд аль аль шатанд нь ажиллаж байгаа энэ хүмүүсийн зовлон, жаргалыг сонсох хэрэгтэй юм байна лээ шүү. Тэрнээс зүгээр хэдэн дарга гишүүд, сайд нарын үзэмжээр хандсан хуулийг бол бид нар хийж болохгүй гэж бодож байгаа юм. Монгол улс онцлогтой. Бид нар бол өөрсдийн үндэс угсаа, соёл хүмүүжил, өв уламжлалтай. Энэ гишүүдийн яриад байгаа тэр үндэсний уламжлал, үндэсний өв соёл, үндэсний хүмүүжил, ах захаа хүндлэх, дээдлэх энэ бүх юмыг шингэсэн, ялангуяа сургуулийн болон сургуулийн өмнөх боловсролын түвшинд энэ юмнуудыг их сайн оруулж ирээсэй гэж ингэж хүсэж байгаа. Дээрээс нь миний түрүүн ярьдаг гадуур бол ямар хэвлэл мэдээллээр бас юу явж байгаа вэ гэхээр мэдээж энэ хувийн хэвшлийн сургуулиудыг чанаржуулах, сайжруулах, шахаж шаардах, ажиллах шаардлага байгаа. Гэхдээ зөвхөн төрийн сургуулиудыг дэмжсэн ийм бодлогыг хуульчилж бас монополчилж явж болохгүй шүү. Хэрвээ ийм асуудал байвал энэ дээрээ бас анхаараарай. Зун хэлэлцүүлгүүд дээр энэ асуудал дээр би бас өөрийн байр сууриа илэрхийлнэ гэж бодож байгаа.

Дараагийн нэг зүйл бол хэд хэдэн гишүүд ярилаа. Энэ мэргэжлийн сургалтын асуудлыг шийдэх цаг болсон. 2012-2016 оны үед манай Ардчилсан нам эрх барьж байх үедээ энийг салгачихсан юм. Сайд нарыгаа ажил нь хуваахгүй ч гэсэн нэг яамаа салгаж өгөөд бараг хийх ажил олдохгүй учраас мэргэжлийн сургалтыг боловсролоос салгаад аваачаад өгчихсөн юм. Тэгээд энэ асуудал ингээд гажуудаад ингээд явж байгаа. Энэ их урт түүхтэй ч юм биш. Хэдхэн жилийн түүхтэй. Энэ алдааг бид нар бас цаашдаа засах хэрэгтэй гэж. Ийм ийм зүйлүүдийг анхаараасай гэж бодож байна. Ялангуяа энэ хөдөөгийн боловсролын хоцрогдлыг арилгах хэрэгтэй шүү. 21 дүгээр зууны боловсролын стандарт шаардаад бид нар интернэт байхгүй, гар утас ажилладаггүй, компьютер байхгүй тэр орчинд сурч, боловсорч байгаа хүүхдүүдээс 21 дүгээр зууны хөгжлийн боловсролын стандарт шаардахад хэцүү энийг анхаараарай.

Г.Дамдинням: Одоо цахимаар Цэндийн Мөнх-Оргил гишүүн үг хэлнэ.

Ц.Мөнх-Оргил: Баярлалаа. Засгийн газраас өргөн барьсан боловсролын багц хуулийг хэлэлцэхийг би дэмжиж байгаа юм. Цаг үе олсон 21 дүгээр зууны боловсролын чиг хандлагад таарсан олон чухал заалтууд орж ирсэн байгаа. За 12 жил, боловсрол олгох асуудал, англи хэл 2 дахь хэл болох асуудал дээр олон асуудлууд байна.

Хэлэлцүүлэгт яаж зохион байгуулахтай холбоотой нэг сан байгаа юм. Сая Энх-Амгалан гишүүн хэллээ. Чуулганаас өмнө гишүүдтэйгээ Байнгын хорооны гишүүдтэйгээ хэлэлцүүлэг хийе гэж. Үнэндээ Байнгын хороодын гишүүдээс гадна нийт Улсын Их Хурлын гишүүд, 2 бүлгийн гишүүд бүгдтэй нь том хэлэлцүүлгийг хиймээр байгаа юм. Хууль болгоноор.

Хоёрдугаарт өргөн барьсан хуулиа төслөөр нь интернэт дээр болон хэвлэл мэдээллээр тавьж багш нар, эцэг, эхчүүд өргөн барьсан хуульд энэ зуны хугацаанд саналаа өгөх, санал бодлоо нэмэрлэх бололцоо олгомоор байна. Тэгээд зундаа хэдүүлээ санал бодлыг цуглуулж аваад 8,9 сардаа базаад ингээд л 10, 11 сард энэ төслийг оруулвал яасан бэ гэсэн горимын саналтай байна. Баярлалаа.

Г.Дамдинням: Мөнх-Оргил гишүүн хэлэлцүүлгийг их өргөн хүрээнд зөвхөн Байнгын хорооны хүрээнд биш Их Хурлын гишүүд, бүлэг за бүлгүүд дээр зохион байгуулъя гэж. Санал нэг байгаа. Тэр хэлбэрээр зохион байгуулна. Одоо танхимаар Ундрaм гишүүн. Чинбатын Ундрaм гишүүн үг хэлнэ.

Ч.Ундрaм: Хуулийн төслийг зарчмын хувьд их дэмжиж байгаа. Ер нь боловсролын салбар бол маш удаан энэ хуулийг хүлээсэн. Өргөн хэлэлцүүлгүүд явагдсан байгаа. Тэгээд тэр тусмаа өнөөдөр энэ аж үйлдвэрийн 4 дүгээр хувьсгалын эрин үед бид нар дэлхийд өрсөлдөх чадвартай Монгол иргэдийг бэлдэх ёстой. Яг тэр рүү чиглэсэн ийм хууль болж батлагдах ёстой гэж үзэж байгаа. Яг энэ үед Дээд боловсролын тухай хууль дээр нэлээд барууны шинж чанартай, олон улсын шинж чанартай өөрчлөлтүүд орж ирж байгаад бол маш талархалтай хандаж байгаа юм. Бид нар дээд сургууль бол ерөөсөө мэдлэг бүтээдэг байгууллага байх ёстой. Судалгаа хийдэг, инновац бий болгодог. Тэрний төлөө энэ шалгууруудыг өндөрсгөх ёстой. Олон улсын дээд боловсролын байгууллагын ранкыг тогтооход хамгийн гол шалгуур нь web of science-д бүртгэлтэй Thomson reuters-ийн индекстэй сэтгүүлд өгүүлэл хэвлүүлсэн үү, хэд хэвлүүлсэн бэ гээд энэ судалгааны чанар чансаагаар нь хамгийн түрүүнд үнэлдэг байгаа. Ерөөсөө бүх сургуулийг.

Тийм учраас бид нар энэ шаардлагуудыг өндөрсгөх нь маш чухал ч ач холбогдолтой байгаа юм. Цаашлаад бас нэлээн шинэчлэлүүдийг оруулах ёстой. Жишээлбэл бид нар энэ профессор зэрэглэл цол гээд 2 тусдаа юм яваад байдаг. Тэгэхээр бүр тэр систем рүү нь оруулж өгөх ёстой. За засаглалыг нь ч гэсэн бид нар төрөөс хараат бус болох ёстой. Энэ хуулийн төсөл дээр бол 51 хувийг нь Засгийн газраас томилно гэхихсэн байна. Бид нар энийг хараат бус Мерит зарчмаараа өөрөө өөрийгөө удирдаад аваад явдаг, төрөөс хараат бус болох ёстой. Дээрээс нь доторх энэ зохион байгуулалтыг нь ч гэсэн президент гээд явдаг шүү дээ. Манайх чинь ректор, ректорат гээд, ингээд проректор гээд явдаг. Тэгэхээр энийг нь бид нар ингэж зөв зарчим руу оруулах ёстой. Мөн элсэлтийн бодлогоо ч гэсэн шинэчлэх ёстой. Элсэлтийн ерөнхий шалгалтыг жилд хэд хэдэн удаа, 2 ч биш бүр 3, 4 авдаг. Хүүхдүүд бэлдээ, заримдаа сэтгэл санаа, биеийн байдал нь муу байж болно шүү дээ. Бэлдээд өөрсдийгөө сайжруулаад ЭЕШ-аа өгөөд их сургуульдаа ордог боломжтой болох ёстой. Дээрээс нь элсэлтийн бодлогод жендерийн асуудлыг оруулж ирэх ёстой. Зарим мэргэжил дээр дандаа охидууд ороод байдаг, заримд нь хөвгүүд ороод байдаг. Мөн Монгол улсын энэ бага хүн амтай том газар нутагтай шинж чанарыг тусгаад 21 аймгаас зарим мэргэжилд 1, 1 хүнийг заавал аваад, эргээд нөгөө аймагтаа очоод ажилладаг тэр систем ч гэсэн орох ёстой.

Яагаад гэвэл зарим нэг аймагт эмч нар олдохгүй байна. Багш нар олдохгүй байна. Малын эмч, Хүний эмч гээд олдохгүй байна шүү дээ. Тэгэхээр ийм элсэлтийн бодлогыг өөрсдийнхөө нөхцөл байдалд тааруулж оруулах ёстой. Мөн ахисан түвшний сургалтыг бид нар сайжруулах ёстой. Өнөөдөр яг үнэндээ бол ахисан түвшний сургалтын чанар маш муу байгаа шүү дээ. Энийг сайжруулах ёстой. Элсэлтийн шалгалтыг нь бас энэ европын GMAT.../минут дуусав/

Г.Дамдинням: Ням-Осорын Учрал гишүүн танхимаар.

Н.Учрал: За сая гишүүд бас хэлж байна. Хувийн дунд сургуулиудад хүүхдүүдээ өгөөд Кембрижийн хөтөлбөр хэрэгжүүлж байгаа үнэтэй сургуулиудад хүүхдүүдээ өгснөөс болж түгжрэл үүсээд байна гэж. Тэр сургуулиудад ер нь та бидний хүүхдүүд л сурч байгаа шүү дээ. Тэгээд ардын хүүхдүүдийг болохоор та нар Монгол хэлээ үз гэдэг өөрсдийнхөө хүүхдүүдийг болохоор англи хэл заагаад кембрижийн хөтөлбөр эзэмшүүлье гээд чичрээд дайраад байдаг байж болох юм уу? Энэ хууль гарснаар хүүхэд болгон яг ижилхэн хөтөлбөрөөр англи хэл хүртэж, сонгож сурдаг. Дэлхийн стандартад нийцсэн IGCSE, A level, AS level-ийн сертификатаа авдаг кембрижийн хөтөлбөрийн дагуу суралцдаг, үндэсний онцлогоо шингээсэн тэр хөтөлбөрөөрөө суралцаж төгсөөд дэлхийн ямар ч их, дээд сургуулиудад шалгалт өгөөд тэтгэлэг авдаг, сургалтын төлбөрийн хөнгөлөлт эдэлдэг боломжийг л олгомоор байгаа юм. Тэрнээс биш Баянхошууны сургуульд 10 жил онц сурсан олимпиадад 10 жил түрүүлсэн хүүхэд ч өнөөдөр төгсөөд гарахад Монголын тэр атестатыг чинь дэлхийд зөвшөөрөхгүй байна шүү дээ. Тийм учраас би өнгөрсөн хугацаанд бол нэг л зүйл дээр хатуу байр суурьтай байгаа. Дэлхийн боловсрол бол аль загвараар явах юм бэ? Аль магадлан итгэмжлэл хөтөлбөрийг магадлан итгэмжлэх зөвлөлөөр магадлан итгэмжлүүлвэл хаана ямар сургуулиудад зөвшөөрөгдөх юм бэ, бүсийн хэмжээнд дэлхийн хэмжээнд ямар чанарын баталгаажуулалт хийлгэх ёстой вэ ингэснээрээ ямар сургуулиудад үргэлжлүүлэн суралцах вэ гэдэг замыг нь нээж өгч байдаг. Тэгээд боловсрол өөрөө замыг нээж өгөх л зорилготой байх ёстой байхгүй юу. Тэгэхээр энэ хууль гарснаараа тэр зорилгоо л биелүүлээсэй гэж хүсэж байгаа юм. Тэр тэгш хүртээмжтэй боловсрол гэдэг чинь энэ.

Хоёрт. Энэ хууль дээр аюулгүй байдлын мэргэжлийг төрийн сургуульд явуулна. Төрийн өмчийн анагаахын сургууль дэргэдээ эмнэлэгтэй байна энэ тэр гэдэг зохицуулалтууд байгаа. Энийг хуульд хийж болохгүй. Америкийн одоо конгресс, сенат нь хууль гаргаад хуулиараа Харвардын их сургуулийн бизнесийн хөтөлбөрийг зөвхөн улсын сургууль явуулна гэж хуульчлахгүй шүү. Дэлхийд хаана ч академик эрх чөлөөнд халдсан алхам бүрийг энэ хууль зогсоох ёстой. Тэгэхээр чөлөөт зах зээл рүү довтолсон академик эрх чөлөөнд халдсан ийм үйлдэл огт гаргаж болохгүй. Тэгээд боловсрол бол өөрөө хүнд эрх, эрх чөлөөг бий болгодог зүйл.

Дээрээс нь боловсрол, эрүүл мэнд 2 бол улс орны зүрх тархи нь. Тэгээд би өөрөө энэ боловсролтой, боловсролын энэ салбарт ажиллаж байсан гэр бүлд төрж өссөн. Дээрээс нь европын ректоруудын холбоонд 8 жил удирдах зөвлөлд ажилласны хувьд үүн дээр бол бас чин сэтгэл гаргаж хэлж байгаа юм шүү.

Тэгэхээр ажлын хэсгээ байгуулаад анхааралтай ажиллах ёстой.

Г.Дамдинням: Манай Учрал гишүүн бол их чухал санал хэлж байна. Манай Учрал гишүүн, Булгантуяа гишүүн, Хассуурийн Ганхуяг гишүүн, Ганибалын Амартүвшин гишүүн тэгээд манай Цэрэнжамцын Мөнхцэцэг гишүүн, Чинбатын Ундрэм гишүүн гээд бид ярилцаж байгаад ер нь бол өнгөрсөн жил энэ боловсролын шинэчлэлийн асуудал дээр их томоохон хэлэлцүүлгүүдийг өрнүүлээд сая нэр дурдагдсан гишүүдийн зарим нь миний биеэр ахлуулаад олон улсын хөтөлбөрийг Монголд нутагшуулах тухай асуудлыг бол их тодорхой ярьсан. Бид бол үндсэндээ тавьж байгаа зорилго бол Монголын ерөнхий боловсролын тогтолцоо олон улсын стандартад дүйцэж очих тооцогддог байх. Хүлээн зөвшөөрөгддөг байх. Баянхошуунд, Дарханд, Баянголд, Хан-Уул дүүрэгт гэр хороололд суралцаж байгаа хүүхдүүд олон улсын түвшний боловсролыг өндөр төлбөртэй сургуулийн хүүхдүүдтэй ижилхнээр авдаг энэ боломжийг нээж өгнө л гэдэг энэ асуудлыг ярьж байгаа.

Энэ бодлогын өөрчлөлтийг бол хуулийн төсөлд орж ирсэн гэж болбол харж байгаа. Тэгэхээр энэ чиглэлд бол ажлын хэсгүүд гараад явахаараа бас нэлээн анхаарч ажиллах ёстой. Одоо онлайнаар Балжиннямын Баярсайхан гишүүн үг хэлнэ.

Б.Баярсайхан: За баярлалаа. Тэгэхлээр Боловсролын тухай хууль маань бол Монгол улсын Үндсэн хуулийн дараа орох бидний хөгжлийн ямар иргэнтэй байх вэ. Монгол улс цаашаа яаж хөгжих вэ? энэ улс орныг хэн авч явах вэ гэдгийг тодорхойлох хамгийн гол суурь хууль байгаа юм. Тийм учраас энэ хуулийг батлахад бол хүн болгоны хичээл зүтгэл, сэтгэл хамгийн чухал байгаа. Тэгээд олон гишүүд ерөнхий боловсрол, их, дээд боловсрол, МСҮТ-ийг ярьж байгаа учраас давхардуулахгүй түрүүнийхээ хэлсэн санааг дахин хэлэхийг хүсэж байна. Тэгээд тэр төлөвшил, хандлага чухал гэдгийг бол сайд онцолж байна. Энэ бол маш сайн. Гэхдээ хүүхэд өөрөө шууд төлөвшчихдөггүй. Энэ дээр сайн зан чанарыг хүүхдэдээ суулгаж байж тэр нь цаашаа төлөвшөөд явдаг юм гэдэг энэ дарааллаа бид нар ойлгох ёстой.

Тийм учраас намар энэ хууль хэлэлцэхээс өмнө сайд өөрөө мэдэж байгаа зан чанарын хөтөлбөр хэрэгжүүлэх, тэр суурь судалгаагаа нэгдүгээрт сайн хийх хэрэгтэй байна.

Хоёрдугаарт тэр сайн зан чанартай иргэн бэлтгэх гэдэг дээр энийгээ тэр урьд байсан хуулийнхаа үг хэллэгийг бол оруулж өгөх ёстой. Яагаад? Яагаад гэвэл боловсролоос гадна дахиад хүмүүнлэгийн хууль гээд Бат-Эрдэнэ нарын гишүүний санаачлаад яваад байгаа юм чинь ерөнхийдөө яаж энэ нийгмээ ёс зүйтэй иргэнээр бэлтгэх вэ, яаж Монгол хүн бэлтгэх вэ, яаж Монгол дотортой, ёс жудагтай, сайн төлөвшил, хандлагатай иргэн бэлдэх вэ гэдэг л юм руу яваад байгаа байхгүй юу. Тийм учраас энэ зан чанарын хөтөлбөр, сайн зан чанартаа иргэн бэлтгэх энэ асуудал бол хамгийн суурь асуудал юм шүү гэдгийг бол сануулж хэлье. Тийм учраас сэтгэл зүйчидтэй хамтран ажиллах, тэднийг ашиглах, 0-3 насан, 3-5 насанд 6-аас дээш

насанд яаж сайн зан чанартай иргэн бэлтгэх вэ гэдэг дээрээ анхаарах нь хуулийн гол асуудал юм шүү гэдгийг хэлье . За баярлалаа.

Г.Дамдинням: За Баярсайхан гишүүнд баярлалаа. Одоо Цэрэнжамцын Мөнхцэцэг гишүүн танхимаар.

Ц.Мөнхцэцэг: Тэгэхээр энэ Боловсролын тухай хуулиуд маань агуулга болон зарчмын хувьд маш дэвшилттэй, их шинэлэг заалтууд орж ирсэн сайн хууль орж ирж байна. Тухайлбал Боловсролын тухай ерөнхий хуулийн энэ боловсролын зорилгыг томъёолсон байдал маань хуучин хуультай харьцуулахад бол маш дэвшилттэй байгаад байна. Монгол Улсын ёс уламжлал, үнэт зүйл, ардчилал хүмүүнлэгийн ёс, дэлхийд өрсөлдөхүйц боловсролын зорилго тавьж байгаа гэх мэтээр. Мөн ахлах сургуулийг төрөлжүүлнэ, хувьсах зардлын санхүүжилтийн аргачлалыг шинэчилнэ, англи хэл үндсэн гадаад хэл байна гэх мэтээр. За яагаад вэ гэхээр манай төрийн болон хувийн хэвшлийн сургуулиудын хоорондын хамгийн их ялгаа гарч байгаа хичээл бол англи хэлний боловсрол байдаг. Тийм учраас бид нар төрийн сургуулиудынхаа англи хэлний боловсролыг сайжруулж байж 2 хэвшлийн хоорондын ялгааг бас арилгах, даван туулах боломжтой болж байгаа.

Тэгээд энэ дээр 2,3 саналыг бол ер нь бас тодорхойлон оруулах хэрэгтэй байгаа. тухайлбал төрөөс явуулах ашгийн ба ашгийн бус сургалтын байгууллагын талаарх бодлогыг бид нар хуулийн төсөл дээр маш сайн таниулж өгмөөр байна. Ер нь бол олон улсын чиг хандлага, олон улсын сүүлийн үеийн тогтвортой хуулийн зорилтуудаар бол ашгийн бус байх тал дээр илүү анхаарч явж байна. За хэрэв тухайн хувийн хэвшлийн сургуулиуд нь ашгийн байгаа тохиолдолд төрийн ашгийн бус сургалтын байгууллагад сөрөг нөлөө үзүүлэхгүй байх, олон нийтийн боловсрол эзэмших эрхийг хэрэгжүүлэх чадавхад сөргөөр нөлөөлөхгүй байх тал дээр төрийн бодлогоор дэмждэг юм. Өөрөөр хэлбэл боловсролыг арилжааны хэрэгсэл бус байхыг олон улсын чиг хандлагаар дэмжих ёстой. Үүн дээр манай шинэ хууль бас анхаарах ёстой гэж үзэж байна.

Тэгээд хоёр дахь анхааруулах зүйл нь сүүлийн 2 жилийн цахим болон зайны сургалтын явцад дижитал хуваагдал буюу энэ тэгш бус байдал, мэдээллийн технологид үндэслэсэн хуваагдал бол газар авах гээд байна. Уг нь бол мэдээллийн технологи бол тэгш бус байдлыг багасгаж байх ёстой юм. Гэтэл нэлээд олон улсад тухайлбал манай Монгол улсад бол энэ дижитал хуваагдвал бодит байдал болсон. Тийм учраас цаашид цахим шилжилтийг эрчимжүүлэх, тэр дотроо боловсролын салбар дахь цахим технологи, цахим сургалтыг онцгойлон дэмжих тал дээр хуулийн төсөл маань илүү анхаарна гэдэгт бол итгэж байна.

Дараагийн зүйл нь цар тахлын хуулийн нөхцөлд ер нь манай боловсролын салбар хамгийн их эрсдэлд орсон, хэлмэгдсэн. Тухайлбал боловсролын салбарын маш олон зардлыг танасан байгаа. Үдийн хоолны болон бусад сургуулийн засвар, тоног, төхөөрөмж гэх мэтийг. Энэ бол манай боловсролын салбарт тодорхой хэмжээний эрсдэл учруулсан. Тийм учраас цаашид гамшгийн нөхцөл байдал ч гэсэн

төр бол боловсролыг тасралтгүй олгох, боловсролын болон эрүүл мэндийн салбарын зардлыг ямар ч үед танахгүй байх тал дээр онцгойлон анхаарч байх ёстой гэдгийг энэ дашрамд онцгойлон бас хэлмээр байна. Тухайлбал хүүхдийн 100 мянган төгрөгийн чинь 11 мянга нь боловсролын салбарт хамрагдсан төсөв байгаа шүү. Тийм учраас цаашид хүн амын суурь үйлчилгээ буюу боловсрол, эрүүл мэндийн зардлыг.../минут дуусав/

Г.Дамдинням: Мөнхцэцэг гишүүн үг хэллээ. Одоо Лувсанцэрэнгийн Энх-Амгалан гишүүн.

Л.Энх-Амгалан: Байнгын хорооныхоо гишүүдэд баярлалаа. Манай мэргэжлийн Байнгын хороо Боловсролын ерөнхий хууль дагалдсан хуулиудыг хэлэлцэхийг дэмжиж байгаа. Тэгээд яг энэ хэлэлцүүлэг бас жаахан дутуу хийгдсэн байна гэж ойлгож байна. Тэгээд ерөнхийдөө түрүүн Байнгын хорооны даргад гаргасан саналын дагуу эхлээд ямар ч байсан энэ Байнгын хорооныхоо түвшинд бид нар мэдээлэл, ойлголт нэг түвшинд аваачихгүй бол чуулганы үеэр энэ чинь хэлэлцэх эсэх нь дэмжигдэж байгаа хууль учраас болоогүй юмыг болсон мэтээр орж ирээд хий дэмий төөрөгдөл гарах вий дээ гэж бас тийм болгоомжлол байна. Байнгын хороон дарга аа. Жишээ нь төрийн сургуулийн монополийг баталгаажуулсан хууль гэх ч юм уу, эсвэл өмчийн ямар нэгэн хэлбэрийг хязгаарласан, болсон хууль ч гэдэг юм уу гэх мэтчилэнгээр багш нарын тэтгэврийн настай ч холбоотой гэдэг юм уу, шинэчлэлийг илүү их зөв ойлгуулах, зөв тооцоо судалгаан дээр үндэслэсэн үндэслэлүүдээр бид нар энэ хэлэлцүүлгүүдийг хийхгүй болбол ингэж нэг өнцгөөр ярихад их хэцүү.

Яагаад гэвэл энэ өөрөө яг үндэсний зөвшилцлийн хүрээнд гарах хууль учраас илүү их олон хэлэлцүүлэг хийж байж бид нар нэгдсэн ийм байр суурьтай болно. Тэгэхээр өчигдөр Ардчилсан намын бүлэг дээр мэдээлэл хийсэн. Өөрийнхөө Монгол ардын намын бүлэг дээр бас мэдээлэл хийсэн. Энэ бүх мэдээллүүдийн дагуу та бүгд маань өнөөдөр яг манай зөвхөн Байнгын хорооныхоо гишүүдэд л өнөөдөр амжиж, зориулж энэ 8 ажлын хэсгийн ажилласан энэ тайлангуудыг ном болгож хүргэж байгаа.

Энэ тайлан дээр гаргасан зөвлөмжийн дагуу л үндсэндээ энэ өөрчлөлтүүдийг хийх ийм зайлшгүй шаардлага гарсан юм. Тэгэхээр яагаад хуулиа өргөн барихгүй татаад цаг хугацаа алдав гэсэн бас шүүмжлэлүүд гарч байх шиг байгаа юм. Үнэхээр дутуу хууль бид нар баталж болохгүй. Тийм учраас өнөөдөр энэ боловсролын тэр тусмаа Боловсролын ерөнхий хуулийн амин сүнс болсон гол гол зүйлүүдийг хийхгүйгээр ингэж дутуу алсан могой шиг болгож болохгүй л дээ. Тэгээд цаг хугацаа алдчихсан асуудал биш, илүү их гүйцээн боловсруулсан асуудал байгаа юм шүү гэдгийг гишүүд маань бас зөвөөр ойлгоорой гэж бодож байгаа. Хэд хэдэн зүйлүүдийг бас яг энэ нэмж гүйцээн боловсруулах дээр бид нар оруулсан.

Нэгдүгээрт бол амьдралын орчноосоо суралцах энэ асуудал насан туршийн боловсролын асуудлыг бол Монголынхоо боловсролын тогтолцооны салшгүй нэг хэсгийг албан ёсоор хуулиараа хүлээн зөвшөөрөх ёстой. Нэгдүгээр асуудал.

Хоёрдугаар асуудал бол заавал эзэмших боловсролыг 1-12 дугаар анги байх ёстой. Ийм зайлшгүй нийгмийн хэрэгцээ шаардлага өнөөдөр үүсэж байна.

Гуравдугаар асуудал бол мэдлэг чадвар, төлөвшил дээр ангилсан энэ мэргэжлийн үндэсний шаталсан бүтцийг бий болгох ийм зайлшгүй шаардлага. Өнөөдөр энийгээ бий болгож байж л үндсэндээ боловсролын түвшин, боловсролын тогтолцоогоо бид нар зөв болгох ёстой юм байна лээ. Тэгээд цаашдаа бол энэ англи хэл, боловсролын чанарын баталгаажуулалтын асуудал, үр дүнд суурилсан санхүүжилт гэх мэтчилэнгээр сургуулийн хэв шинж статусын асуудлуудыг бид нар ингэж шинэчлэх зайлшгүй.../минут дуусав/

Г.Дамдинням: За Боловсролын ерөнхий хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэхтэй холбоотой асуудлуудыг бид ярьж байна. Гишүүд бол үнэтэй саналуудыг хэлж байна. Нийгмийн үндсэндээ бараг 60-аас илүү хувь нь 1.6 сая хүн шууд холбогддог ийм салбар. Энэ салбарын суурь өөрчлөлт бол Монгол орны ирээдүйн хөгжилтэй холбоотой. Энэ өөрчлөлт шинэчлэлтийг ялангуяа манай Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо гишүүд, мэргэжлийн гишүүд энэ салбарт ажиллаж байсан гишүүд улс төрийн манлайлал үзүүлж, нийгмийг талцуулахгүй, хуваагдуулахгүй зөв ойлгуулж, нийгмийн зөвшилцлөөр энэ хуулийг авч бид өөрчлөлтийг хийх ёстой. Бүх оролцогч талуудын саналыг сонсоно. Тэр дундаа энэ шийдвэр гаргагчдыг бол маш сайн ойлгуулах ажлыг нь Боловсролын яамтай хамтарч хийнэ. Эцэг, эхчүүдийн саналыг авна, Сурагчдын саналыг авна, Энэ салбарт ажиллаж байгаа ажилтан, албан хаагчид багш нарынхаа саналыг авна. Дээд, дунд, сургуулийн өмнөх гээд бүгдээс нь авна. Тэгээд нийгмийн зөвшилцлийн ажил үндсэндээ өнөөдөр энэ хууль Байнгын хороогоор анхны хэлэлцүүлгээрээ хэлэлцэх эсэх нь ороод, дараа нь үргэлжлүүлээд чуулганаар хэлэлцэх хэсэг орно. Энэний дараа бүх зүйл хэлэлцүүлгийн түвшинд нээлттэй явна гэдгийг бол энэ хуралдааныг харж байгаа хүмүүст хэлье. Тэгэхээр ямар нэг байдлаар хэн нэгний эсвэл хэсэг бүлгийн лоббигоор ямар нэг ийм хууль орж ирж байна гэсэн ийм талцал хуваагдал, хардлага сэрдлэг байхыг бас үгүйсгэхгүй. Тэгээд тийм боломж байхгүй. Нийтээрээ хэлэлцэнэ. Нийтээрээ энэ концепцоо авч үзнэ. Ингээд үүний дараа энэ хууль батлагдах асуудал яригдаж эхэлнэ.

Ингээд үндсэндээ гишүүд үг хэлж дууслаа. Одоо бүртгэлийн санал хураалт явуулъя. Энэ хуулийг хэлэлцэх тухай асуудлыг ярилцах ёстой. Бүртгэлийн санал хураалт явуулъя. Гишүүд тийм гэдэг дээрээ дараарай. Ирцэд байгаа гишүүд. 82.4 хувь бүртгэгдэж байна.

Ингээд Боловсролын ерөнхий хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 88.2 хувийн саналаар Боловсролын ерөнхий хуулийн төсөл болон хамт өргөн мэдээлсэн хуулийн төслүүдийг нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэхийг дэмжлээ.

Байнгын хорооны санал, дүгнэлт унших гишүүнээр Улсын Их Хурлын гишүүн, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны дарга Гонгорын Дамдиннямыг томилъё.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны хэлэлцэх асуудал дууссан тул энэ өдрийн хуралдааныг өндөрлөснийг мэдэгдье. За хуралд идэвхтэй оролцсон гишүүддээ баярлалаа.

Дууны бичлэгээс буулгасан:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ